

**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**



**ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024 ОНЫ
НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН**

АУДИТЫН КОД: ЗАА-2025/001/НА-СТА-ТЭЗ

**Улиастай хот
2025 он**

ᠵᠠᠪᠬᠠᠨ ᠠᠶᠢᠮᠠᠭ ᠳᠠᠬᠤ
ᠲᠥᠷᠢᠶᠢᠨ ᠠᠭᠤᠳᠢᠲᠤ ᠶ᠋ᠢᠨ ᠭᠠᠰᠠᠷ
ᠵᠠᠪᠬᠠᠨ ᠠᠶᠢᠮᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠨᠢᠭᠦᠳᠦᠰᠦᠨ ᠲᠥᠰᠦᠪᠢᠶᠢᠨ ᠭᠤᠶᠢᠴᠡᠲᠦᠭᠡᠯᠳᠦ
ᠬᠢᠶᠢᠰᠢᠨ ᠠᠭᠤᠳᠢᠲᠤ ᠲᠠᠶᠢᠯᠠᠨ

АГУУЛГА

БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ТАТВАРЫН ОРЛОГО ТӨЛӨВЛӨСНӨӨС ДАВЖ БИЕЛСЭН Ч ЗАРИМ НЭР ТӨРӨЛД ТАСАРСАН БАЙНА.....5

1.1 Сангийн яам орон нутгийн орлогыг 1,373.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж, санхүүгийн дэмжлэгийг 311.4 сая төгрөгөөр бууруулан тодотгожээ. 5

1.2 Орон нутгийн татварын орлого төлөвлөгөөнөөс давж биелсэн боловч 7 нэр төрлийн орлого тасарсан байна. 6

1.3 Нэмэлтээр бий болсон орлогыг төсөвт бүрэн тусгасан байна. 8

БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН НИЙТ ЗАРДЛЫГ САНГИЙН ЯАМНЫ ХЯНАСАН СУУРЬ ЗАРЛАГААС 29.7 ХУВИАР НЭМЭГДҮҮЛЭН БАТАЛЖЭЭ.....9

2.1 Орон нутгийн 2024 оны төсвийн нийт зардалд эзлэх урсгал зардлын хэмжээ өмнөх оноос 41.3 хувиар өссөн нь төсвийн үр ашгийг дээшлүүлэх бодлоготой уялдахгүй байна. ...9

2.2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны нийт төсвийн гүйцэтгэл 91.3 хувьтай байна. Орон нутгийн хөрөнгө оруулалт, аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ төлөвлөсөн үр дүнд хүрээгүй нь нэгдсэн төсвийн гүйцэтгэлд сөргөөр нөлөөлж байна. 10

2.3 Төсвийг үр ашиггүй, хэт үрэлгэн, зориулалт бусаар зарцуулсан зөрчил буурахгүй, жил бүр давтагдан гарч байна..... 12

2.4 Шат, шатны Засаг даргын нөөц хөрөнгийг орон нутгийн давсан орлогоос нэмэгдүүлэн баталж байгаа нь төсвийг үр ашиггүй үрэлгэн зарцуулах нөхцөлийг бүрдүүлж байна. 15

2.5 ТЕЗ-ийн харьяа байгууллагууд ОНХС-ийн хөрөнгийг урсгал зардал болон журам зөрчсөн төсөл арга хэмжээнд төлөвлөж, зарцуулсан, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ гэрээний хугацаанд хийгдээгүй, бүрэн дуусаагүй 3,766.0 сая төгрөгийн зөрчил байна. 17

БҮЛЭГ 3. АЙМГИЙН 2024 ОНЫ ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНӨӨС ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ ХАСАЖ, УРСГАЛ ЗАРДЛЫГ 135.4 САЯ ТӨГРӨГӨӨР САНХҮҮЖҮҮЛЭХЭЭР ТОДОТГОН БАТАЛЖЭЭ.....21

3.1 Хөрөнгө оруулалтын төсвийг зохистой, үр дүнтэй удирдаж, гүйцэтгэлийг бүрэн хангаж ажиллах шаардлагатай байна. 21

БҮЛЭГ 4. ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.....24

4.1 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил өмнөх оноос 771.8 сая төгрөгөөр өссөн байна. 24

4.2 Орон нутгийн өмчит байгууллагуудын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй тээврийн хэрэгслийг 4 удаагийн дуудлага худалдаа зохион байгуулж, орон нутгийн төсөвт 64.2 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. 26

4.3 Шилэн дансны цахим хуудаст тавигдах мэдээллийг журмын дагуу тогтоосон хугацаанд нийтэд мэдээлсэн байна..... 27

БҮЛЭГ 5. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.....28

5.1 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 83.3 хувьтай байна. 28

ДҮГНЭЛТ 30

ЗӨВЛӨМЖ..... 31

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ 32



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ

2025 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/16

Улиастай

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18.9, 18.10 дахь хэсэг, 2023 оны А/102 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтаар баталсан "Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх"-ийн 1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Завхан аймгийн Засаг даргын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл"-д хийсэн аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар, аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Б.Санжсүрэн, аймгийн Засаг дарга Г.Өнөрбаяр нарт хүргүүлэхийг аудитор (Г.Баасанжаргал)-д даалгасугай.

3. Аудитаар хүргүүлсэн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж, биелэлтийг 2025 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлэхийг аймгийн Засаг дарга Г.Өнөрбаярт зөвлөсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Х.Болдбаатар)-т үүрэг болгосугай.



Д.БАТ-УНДРАА

D/Албан бичиг/Тушаал-А/2025
012501010

**АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, СТАНДАРТ,
АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

**Аудит хийх
үндэслэл, бүрэн
эрх**

Аудитыг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2022 оны 9 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/04 дүгээр тушаал, Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.

Аудитын зорилт

Завхан аймгийн Засаг даргын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхийг аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аудитыг гүйцэтгэж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан, дүнг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, холбогдох албан тушаалтнуудад танилцуулахад чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

1. Орон нутгийн 2024 оны төсвийн орлогыг бодитой тооцож төлөвлөн, бүрэн төвлөрүүлсэн эсэх;
2. Орон нутгийн 2024 оны төсвийн зардлыг бодитой тооцож төлөвлөн, зориулалтын дагуу зарцуулсан эсэх;
3. Аймгийн төсвийг төсвийн бодлого, бүсчилсэн хөгжлийн бодлого, жилийн хөгжлийн төлөвлөгөөтэй нийцүүлэн төлөвлөж, хэрэгжилтийг хангаж ажилласан эсэх;
4. Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан эсэх;
5. Өмнөх аудитын болон аймгийн 2024 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитын шийдвэрийн хэрэгжилт бүрэн хангагдсан эсэх;

**Аудитын
хамарсан хүрээ**

Завхан аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан, аймаг, сумдын ИТХ-ын хуралдааны тогтоол, аймгийн Засаг даргын захирамж, аймгийн Татварын газрын аудитад хамрагдах татварын төлөвлөгөө, тайлан, Сангийн яамнаас Завхан аймгийн 2024 оны аймгийн төсвийн суурь, орлого зарлагыг хянаж ирүүлсэн тооцоо болон бусад материалд тулгуурлан аудитыг гүйцэтгэв.

**Аудитын арга
зүй, шалгуур
үзүүлэлт**

Монгол улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020, MNS 6817-4:2020 “Төрийн аудит. Санхүүгийн аудит”, 6817-6 :2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит” стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн МУЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан ТАБ-аас аудит хийх журам, МУЕА-ын 2021 оны А/71 тушаал “Заавар аргачлал батлах тухай” журмын аргачлалыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав.

**Аудитын арга
зүй, шалгуур
үзүүлэлт**

Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Тусгай сангийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Төрийн аудитын байгууллагаас 2023-2024 онд гүйцэтгэх аудитад баримтлах ерөнхий чиглэл
- Завхан аймаг, сумдын ИТХ-ын хуралдааны тогтоолууд
- Холбогдох бусад хууль, журам эрх зүйн акт

**Аудитын багийн
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар хэрэгжүүлж, ахлах аудитор Ц.Оюунсүвд, аудитор Г.Баасанжаргал, О.Алтансүвд, П.Номинзул нар 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлэн, 04 дүгээр сарын 21-ний өдөр хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэв.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

**АДБОУС
АИТХ
ИТХ
ТЕЗ
ЗДТГ
ОНХС
СЯ
ХХС
СТСХ
ХХОАТ
ААНОАТ
ҮХЭХ
ТХААГ
НДШ
ХХААЯ
ОНӨГ**

Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
Төсвийн ерөнхийлөн захирагч
Засаг даргын Тамгын газар
Орон нутгийн хөгжлийн сан
Сангийн яам
Хоршоог хөгжүүлэх сан
Санхүү, төрийн сангийн хэлтэс
Хувь хүний орлогын албан татвар
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
Үл хөдлөх эд хөрөнгө
Төрийн худалдан авах ажиллагааны газар
Нийгмийн даатгалын шимтгэл
Хүнс хөдөө аж ахуйн яам Орон нутгийн өмчийн газар
Орон нутгийн өмчийн газар

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай, Төрийн албаны тухай, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Хөдөлмөрийн тухай, Татварын ерөнхий хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсон, Засгийн газрын 2024 оны 128 болон 238 дугаар тогтоолоор төрийн албаны зарим тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоосон байна.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар Завхан аймагт олгох санхүүгийн дэмжлэгийг 37,893.3 сая төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгийг 14,040.3 сая төгрөгөөр анх баталж, тодотгосон төсвийн тухай хуулиар санхүүгийн дэмжлэгийг 311.5 сая төгрөгөөр бууруулж, 37,581.8 сая төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгийг 660.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 14,700.7 сая төгрөгөөр баталсан байна.

Завхан аймгийн ИТХ-ын хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 94 дүгээр тогтоол, сумдын ИТХ-ын хуралдааны тогтоолоор орон нутгийн төсөвт төвлөрөх татварын орлогыг 26,951.1 сая төгрөгөөр, татварын бус орлогыг 1,164.6 сая төгрөг, улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 37,893.3 сая төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгийг 14,040.3 сая төгрөгөөр, урьд оны үлдэгдлээс 16,429.6 сая төгрөгөөр, төсөвт байгууллагын өөрийн орлогыг 151.6 сая төгрөгөөр, нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 96,630.5 сая төгрөгөөр, 2024 онд аймгийн төсвөөс зарцуулах нийт зарлагыг 96,630.5 сая төгрөгөөр анх баталжээ.

БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ТАТВАРЫН ОРЛОГО ТӨЛӨВЛӨСНӨӨС ДАВЖ БИЕЛСЭН Ч ЗАРИМ НЭР ТӨРӨЛД ТАСАРСАН БАЙНА.**1.1 Сангийн яам орон нутгийн орлогыг 1,373.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж, санхүүгийн дэмжлэгийг 311.4 сая төгрөгөөр бууруулан тодотгожээ.**

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар Завхан аймгийн Засаг дарга Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний дагуу санхүүгийн дэмжлэгээр 37,581.9 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 14,700.7 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Хүснэгт 1. Аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлэг

/сая.төгрөгөөр/

ОНХНС-с ОНХС-д олгох орлогын шилжүүлэг			Улсын төсвөөс ОНХС-д олгох орлогын шилжүүлэг		Аймаг, нийслэлийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн нийт дүн
ГТНАТ-н 30%	АМНАТ-н 10%	ЖГҮ	АМХТЗ-н 100%	АМАТЗ-н 50%	
355.7	13,468.6	562.4	82.2	231.9	14,700.7

Завхан аймгийн ЗДТГ-ын СТСХ-ээс татварын орлогыг 9,593.6 сая төгрөгөөр, татварын бус орлогыг 1,536.2 сая төгрөгөөр, нийт 11,129.8 сая төгрөгөөр төлөвлөж хүргүүлснийг Сангийн яамнаас татварын орлогыг 17,143.9 сая төгрөгөөр, татварын бус орлогыг 1,013.6 сая төгрөгөөр, нийт 18,157.5 сая төгрөгөөр хянаж баталсан байна.

Монгол Улсын 2024 оны тодотгосон төсвийн тухай хуулиар татварын болон татварын бус орлогыг 1,373.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 19,531.2 сая төгрөгөөр, санхүүгийн дэмжлэгийг 311.4 сая төгрөгөөр бууруулан, 37,581.8 сая төгрөгөөр баталжээ.

ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Хүснэгт 2. ОНТ-ийн суурь орлого, зарлага

/сая.төгрөгөөр/

Тайлант он	Суурь орлого	Суурь зарлага	Тэнцэл	Орон нутгийн төсөвт үлдэх	Улсын төсөвт төвлөрүүлэх	Санхүүгийн дэмжлэг
2024 батлагдсан	18,157.6	56,050.8	(37,893.3)	0.0	0.0	37,893.3
2024 тодотгосон	19,531.2	57,113.0	(37,581.9)	0.0	0.0	37,581.9
Зөрүү	1,373.6	1,062.2	311.4	0.0	0.0	(311.4)

Завхан аймгийн ИТХ-ын хуралдааны 2024 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 09 дүгээр тогтоол, сумдын ИТХ-ын хуралдааны тогтоолоор орон нутгийн төсөвт төвлөрөх татварын орлогыг 22,497.4 сая төгрөгөөр, татварын бус орлогыг 1,774.6 сая төгрөг, улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 37,581.8 сая төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгийг 14,700.7 сая төгрөгөөр, урьд оны үлдэгдлээс 16,429.6 сая төгрөгөөр, төсөвт байгууллагын өөрийн орлогыг 151.6 сая төгрөгөөр, нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 93,135.8 сая төгрөгөөр баталжээ.

Сумдын төсөвт байгууллагууд татварын давсан орлогоос 8,568.9 сая төгрөгөөр, урьд оны үлдэгдлээс аймаг 4,593.8 сая төгрөгөөр, сумд 3,266.9 сая төгрөгөөр санхүүжихээр төлөвлөсөн байна. Харин тайлант онд Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлогыг тусад нь төлөвлөөгүй, давсан орлогын дүнд төлөвлөж тайлагнасан байна.

1.2 Орон нутгийн татварын орлого төлөвлөгөөнөөс давж биелсэн боловч 7 нэр төрлийн орлого тасарсан байна.

Орон нутгийн төсвийн суурь орлогыг өмнөх оноос 3,692.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна. Хувь хүний орлогын албан татварын буцаан олголтод 2024 онд 1,208.7 сая төгрөг олгохоор төлөвлөж, татварын суурь орлогоос хасаж хянасан байна.

Аймгийн ИТХ-ын 2023 оны 94 дүгээр тогтоолоор 2024 оны татварын орлогын төлөвлөгөөг ААНОАТ-ыг 8,292.1 сая төгрөгөөр, хүү торгуулийн орлогыг 0.5 сая төгрөгөөр бууруулж, малын тоо толгойн албан татвар 500.0 сая төгрөгөөр, хөрөнгийн орлого, хүүгийн орлогыг 80 сая төгрөгөөр, хөрөнгө борлуулсны орлого (ҮХЭХ, Газрын эрх борлуулсан) 50.0 сая төгрөгөөр, цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын албан татварыг 165.0 сая төгрөгөөр, үл хөдлөх хөрөнгийн албан татвар 65.0 сая төгрөгөөр, ан амьтны нөөц ашигласны төлбөрийг 40.0 сая төгрөгөөр, хог хаягдлын үйлчилгээний хураамжийг 90.0 сая төгрөгөөр, нийт 8,841.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталж, 2024 оны 09 дүгээр тодотголоор ААНОАТ-ыг 8,292.1 сая төгрөгөөр бууруулсан байна. Энэ нь “Баян-айраг эксплорейшн” ХХК-ийн үйл ажиллагаа хэвийн явагдахгүй болсонтой холбоотой байна.

Татварын орлогын 2024 оны мэдээг үндэслэн төлөвлөгөө, гүйцэтгэлийг харьцуулахад тайлант онд татварын орлого давж биелсэн байна. Үүнд:

Хүснэгт 3. Татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

№	Татварын орлогын төрөл	Төлөвлөгөө	Нэмэлт даалгавар /АИТХ/	Төлөвлөгөө	АИТХ-аар тодотгосон	Нийт төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт /хувиар/
		/СЯ тодотгосон/		/СЯ тодотгосон/				
ХХОАТ	Малын тоо толгойн албан татвар	-	500.0	-	684.3	684.3	648.3	94.7
	Галт зэвсгийн албан татвар	54.0	-	54.0	-	54.0	65.4	121.1

ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

	Хөрөнгийн орлого /хүүгийн орлого/	1,066.9	80.0	1,066.9	80.0	1,146.9	200.7	17.5
	Хөрөнгө борлуулсны орлого/ ҮХЭХ, Газрын эрх борлуулсан /	90.0	50.0	180.0	(30.0)	150.0	346.0	230.6
	Үйл ажиллагааны орлогын албан татвар	500.0	-	1,900.0	(1,400.0)	500.0	907.7	181.5
	Шууд бус орлого / СХХООСАТ/	109.0	-	800.0	929.1	1,729.1	2,841.6	164.3
	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	12,330.0	165.0	11,830.0	4,076.3	15,906.3	17,739.7	111.5
	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	600.0	65.0	600.0	65.0	665.0	1,103.0	165.9
	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татвар	-	-	-	-	-	1.0	
	Дүн	14,750.0	860.0	16,430.9	4,404.8	20,835.7	23,853.3	114.5
	ХХОАТ-ын буцаан олголт	(1,116.6)	-	(1,120.0)	(11.7)	(1,131.7)	(1,208.7)	106.8
Бусад татвар	Улсын тэмдэгтийн хураамж /ТТХ-23.4.9 бусад/	70.0	-	70.0	-	70.0	198.4	283.5
	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	30.0	-	290.0	-	290.0	170.4	58.8
	Ойн нөөц ашигласны төлбөр	350.0	-	350.0	80.0	430.0	388.1	90.2
	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	119.3	40.0	119.3	40.0	159.3	563.5	353.7
	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	11.8	-	11.8	10.0	21.8	3.9	17.8
	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	12.0	-	12.0	15.2	27.2	11.4	42.1
	Газрын төлбөр	714.4	-	714.4	54.8	769.2	928.2	120.7
	Дуудлага худалдаа	-	-	126.0	(126.0)	-	204.2	
	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	150.0	150.0	150.0	34.4	184.4	117.1	63.5
	Бусад татвар	-	-	221.0	329.0	550.0	84.8	15.4
	Дүн	340.9	190.0	944.5	425.7	1,370.2	1,461.4	106.7
Татварын бус	Хүү торгуулийн орлого	330.0	-	30.0		30.0	160.0	
	Нэр заагдаагүй орлого	-	-	13.6	(13.6)	-		
	Дүн	330.0	-	43.6	(13.6)	30.0	160.0	
Сумын төсвийн орлогын дүн		15,420.9	1,050.0	17,419.1	4,816.9	22,235.9	25,474.7	114.6
Аймгийн төсвийн орлого	ААНОАТатвар /40%/	1,000.0	7,791.6	500.0	-	500.0	1,436.0	287.2
	АТБЭЯХ-ийн албан татвар	430.0	-	430.0	-	430.0	546.4	127.1
	Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр	260.0	-	-	-	-		
	Улсын тэмдэгтийн хураамж /ТТХ-23.4.9 бусад/	212.1	-	212.1	(100.0)	112.1	200.0	178.4
	Татварын хүү,торгууль, алдангийн орлого	151.0	-	970.0	(849.0)	121.0	2,012.9	1,663.6
	Татварын бус хүү, торгууль	683.6	-	-	1,073.6	1,073.6	1,324.4	123.4
Аймгийн төсвийн орлогын дүн		2,736.7	7,791.6	2,112.1	124.6	2,236.7	5,519.7	246.8
Орон нутгийн төсвийн нийт орлого		18,157.6	8,841.6	19,531.2	4,941.5	24,472.6	30,994.4	126.6

ААНОАТ-ын батлагдсан төлөвлөгөөг Засгийн газрын санхүүгийн цахим системийн төлөвлөгөөнд 399.6 сая төгрөгөөр илүү тусгасан байна. Аймгийн Татварын газар нь зарим татварын орлогыг илүү, дутуу дүнгээр төлөвлөж, зарим орлогыг огт төлөвлөдөггүй зэргээс шалтгаалж байна.

ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2024 онд орон нутгийн татварын орлого 30,994.4 сая төгрөг (татварын буцаан олголт 1,208.7 сая төгрөгийг хассан) төвлөрч, 26.6 хувиар давж биелжээ.

Төрийн аудитын газраас 2024 онд 10 нэр төрлийн орлогыг 1,350.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэхээр санал оруулж, аймгийн ИТХ-ын зөвлөлийн 2023 оны 11 сарын 27-ны 06 дугаар тэмдэглэлээр 7 нэр төрлийн орлогыг 1,050.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэхээр аймгийн Татварын газарт үүрэг болгожээ. Орон нутгийн өмч борлуулсны болон түрээсийн орлого, газрын дуудлага худалдааны орлого, төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөөг нэмэгдүүлэх оруулсан боловч газрын дуудлага худалдааны орлогыг төлөвлөх боломжгүй гэх шалтгаанаар тодотголоор төлөвлөгөөнөөс хассан байна.

Аймгийн ИТХ-аас нэмэлт даалгавраар өгсөн 7 нэр төрлийн орлогоос хөрөнгө борлуулсны орлого (ҮХЭХ, Газрын эрх борлуулсан), үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар, цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын албан татвар, ан амьтны нөөц ашигласны төлбөр, хөрөнгийн орлого, хүүгийн орлого, 1,925.3 сая төгрөгөөр буюу 10.7 хувиар давж биелсэн. Малын тоо толгойн албан татвар, хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого биелээгүй байна.

Хүснэгт 4. Сумдын татварын орлогын гүйцэтгэл

/сая.төгрөгөөр/

№	Сумдын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Алдархаан	324.7	688.5	363.8	212.0
2	Асгат	296.7	510.1	213.4	171.9
3	Баянтэс	294.8	629.0	334.2	213.4
4	Баянхайрхан	2,056.1	3,016.0	959.9	146.7
5	Дөрвөлжин	1,455.5	2,239.3	783.8	153.9
6	Завханмандал	297.1	541.7	244.6	182.3
7	Идэр	331.4	545.9	214.6	164.8
8	Их-Уул	593.8	1,129.6	535.8	190.2
9	Нөмрөг	259.8	452.2	192.4	174.0
10	Отгон	262.5	488.7	226.2	186.2
11	Сантмаргац	271.8	391.6	119.8	144.1
12	Сонгино	212.0	351.5	139.5	165.8
13	Тосонцэнгэл	297.2	434.8	137.6	146.3
14	Тэлмэн	608.0	1,089.4	481.4	179.2
15	Тэс	312.5	644.5	332.0	206.2
16	Түдэвтэй	292.6	819.5	526.9	280.0
17	Улиастай	7,750.3	11,392.8	3,642.5	147.0
18	Ургамал	218.2	343.9	125.7	157.6
19	Цагаанхайрхан	203.8	350.7	146.9	172.1
20	Цагаанчулуут	262.8	437.3	174.5	166.4
21	Цэцэн-Уул	293.9	426.3	132.4	145.0
22	Шилүүстэй	223.1	426.0	202.9	190.9
23	Эрдэнэхайрхан	257.3	326.4	69.1	126.8
24	Яруу	211.1	283.2	72.1	134.2
Дүн		17,587.0	27,958.9	10,371.90	

Аймгийн Татварын газрын 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчилд дүн шинжилгээ хийхэд албан хаагчдад үр дүнгийн мөнгөн урамшууллыг холбогдох журмыг зөрчин, хавтгайруулан олгосон 67.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн байна.

1.3 Нэмэлтээр бий болсон орлогыг төсөвт бүрэн тусгасан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудад тайлант онд нэмэлтээр нийт 9,418.2 сая төгрөгийн орлого төвлөрч, зарцуулсан байна.

ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Хүснэгт 5. Нэмэлт санхүүжилтийн орлого

/сая.төгрөгөөр/

№	Орлогын төрөл	Өмнөх он	Тайлант он
1	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,326.1
2	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	138.1	982.8
3	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,058.6	7,110.8
ДҮН		5,196.7	9,419.7

Нэмэлт санхүүжилтийн дансаар улсын төсөвт байгууллагаас олгосон санхүүжилт, автозамын сан, орон нутгийн хөрөнгө оруулалт, аймгийн ОНХС-аас эрх шилжсэн ажлын санхүүжилт, худалдан авах ажиллагааны тендерийн бичиг баримтын үнэ, Орон нутгийн өмчийн газар дуудлага худалдааны орлого зэрэг дамжсан байна. Орон нутгийн өмчийн газар нь Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн түрээслэгчтэй байгуулсан 21 байгууллагын түрээсийн гэрээг бүрэн шинэчлэн баталгаажуулж, гэрээний хэрэгжилтийг хянан ажиллаж, төсөвт 23.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогыг 151.6 сая төгрөгөөр төлөвлөж, 140.7 сая төгрөгийг бүрдүүлсэн байна.

Хүснэгт 6. Төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая.төгрөгөөр/

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өөрчлөлт	Хувь
Түдэвтэй сумын Ойн анги	3.5	3.7	0.2	1.4
Тосонцэнгэл сумын Ойн анги	31.4	31.5	0.03	0.3
Байгаль орчны газар	1.6	0.5	(1.1)	(10.1)
Аймгийн Засаг даргын Тамгын газар	15.1	5.1	(9.9)	(91.5)
Баруун бүсийн тамирчдыг олимпод бэлтгэх төв	100.0	100.0	-	100.0
Дүн	151.6	140.8	(10.9)	-

БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН НИЙТ ЗАРДЛЫГ САНГИЙН ЯАМНЫ ХЯНАСАН СУУРЬ ЗАРЛАГААС 29.7 ХУВИАР НЭМЭГДҮҮЛЭН БАТАЛЖЭЭ.

2.1 Орон нутгийн 2024 оны төсвийн нийт зардалд эзлэх урсгал зардлын хэмжээ өмнөх оноос 41.3 хувиар өссөн нь төсвийн үр ашгийг дээшлүүлэх бодлоготой уялдахгүй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч нь 2024 онд урсгал зардлыг өмнөх оноос 16,358.9 сая төгрөгөөр буюу 29.2 хувиар, хөрөнгийн зардлыг 9,279.0 сая төгрөгөөр буюу 27 хувиар нэмэгдүүлж, эргэж төлөгдөх цэвэр зээлийн зардлыг 201.0 сая төгрөгөөр буюу 7.1 сая төгрөгөөр бууруулж, 22 хөтөлбөр арга хэмжээг нийт 93,135.8 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Орон нутгийн төсвийн 2024 оны нийт зарлагыг Сангийн яамны хянасан хязгаараас 21,322.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталжээ. Урьд оны үлдэгдэл болон татварын давсан орлогоос урсгал зардал, хөрөнгийн зардлыг нэмж баталсантай холбоотой байна.



ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Хүснэгт 7. Аймгийн суурь зарлагын төлөвлөлт

/сая.төгрөгөөр/

№	Зардлын төрөл	Сангийн яам /год/	АИТХ /год/	Зөрүү
1	Аймгийн ИТХ	809.5	1,287.9	478.40
2	Аймгийн ЗДТГ	5,749.8	6,178.8	403.00
3	Ойн анги	283.3	351.7	68.40
4	Байгаль орчны газар	2,058.2	2,250.1	179.30
5	Аймгийн халамжийн сан	113.4	150.0	36.60
6	Санхүүгийн хяналт аудитын алба	388.4	442.6	54.20
7	Орон нутгийн өмчийн газар	343.0	434.9	91.90
8	Хүүхдийн цэцэрлэг /тогтмол зардал/	2,745.6	2,106.6	-656.60
9	Ерөнхий боловсролын сургууль /тогтмол зардал/	9,325.4	7,476.2	-1,771.20
10	Эрүүл мэндийн салбар /тогтмол зардал/	3,379.1	2,982.1	669.70
11	Соёлын салбарын тогтмол зардал	2,104.8	1,425.4	-679.40
12	Мэргэжлийн боловсролын байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	740.7	817.9	77.20
13	Биеийн тамир спортын газар	783.6	1,144.7	361.10
14	Ахмад настны хөгжил хамгаалал	94.8	256.6	161.80
15	Сумдад олгох санхүүгийн дэмжлэг		10,745.9	10,745.90
16	Мал эмнэлгийн үйлчилгээ, эм бэлдмэл	580.2	580.2	0.00
17	Засаг дарга	1401.4	94.1	-1,381.70
18	Хотын нийтийн тээврийн хөнгөлөлт	12.7	12.9	0.00
19	Сумдын ИТХ	4,358.2		-4,358.20
20	Сумдын ЗДТГ	17,611.7		-17,611.70
21	Хот тохижилт үйлчилгээний албан	814.7		-814.70
22	Худалдан авах ажиллагааны алба		364.3	364.3
Дүн		53,698.5	39,102.7	-14,595.6
1	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан	5,925.9	5,925.9	-
2	Их засварын зардал	2,588.9	2,588.9	-
3	Орон нутгийн хөрөнгө оруулалтын зардал	-	10,150.6	10,150.6
4	Авто замын сан	825.6	825.6	-
ДҮН		9,340.4	19,491.0	10,150.6

Хүснэгт 8. Сумдын суурь зарлагын төлөвлөлт

/сая.төгрөгөөр/

д/д	Зардлын төрөл	АИТХ /год/	СИТХ	Зөрүү
1	Сумдын ИТХ	3,424.9	3,860.2	424.50
2	Сумдын ЗДТГ	19,302.9	21,994.9	2,700.90
3	Улиастай сумын ХТҮА	1,305.9	1,763.9	458.00
4	ОНХС	8,774.8	14,836.3	6,061.50
5	Хоршоо хөгжүүлэх сан	-	2,832.8	2,832.80
Дүн		32,808.1	32,810.30	12,477.7

Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 61,853.9 сая төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгээс 14,700.7 сая төгрөгөөр, төсөвт байгууллагын өөрийн орлогоос 151.6 сая төгрөгөөр, урьд оны үлдэгдлээс 16,429.6 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

2.2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны нийт төсвийн гүйцэтгэл 91.3 хувьтай байна. Орон нутгийн хөрөнгө оруулалт, аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ төлөвлөсөн үр дүнд хүрээгүй нь нэгдсэн төсвийн гүйцэтгэлд сөргөөр нөлөөлж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч нь 2024 онд 22 хөтөлбөр арга хэмжээг 93,135.8 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж, төсвийн нийт зарлагын гүйцэтгэл 85,028.3 сая төгрөг буюу 91.3 хувьтай байна. Нийт зардлын гүйцэтгэлийн 62.8 хувийг урсгал зардал, 35.7 хувийг хөрөнгийн зардал, 1.5 хувийг эргэж төлөгдөх цэвэр зээлийн зардал эзэлж байна.

ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Хүснэгт 9. Нийт зарлагын гүйцэтгэл

/сая.төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэмнэлт+Хэтрэлт-	Дүнд эзлэх хувь
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛ	93,135.8	85,028.3	8,107.6	100%
2	УРСГАЛ ЗАРДАЛ	55,975.7	53,421.5	2,554.2	62.8%
3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	53,390.6	50,902.9	2,487.7	59.9%
4	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	22,389.8	21,657.1	732.7	25.5%
5	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,801.5	2,742.7	58.8	3.2%
6	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,150.4	15,221.8	928.6	17.9%
7	Хангамж, бараа материалын зардал	1,113.1	1,095.3	17.8	1.3%
8	Нормативд зардал	189.4	189.4	0.0	0.2%
9	Эд хогшил, урсгал засварын зардал	932.7	885.8	46.9	1.0%
10	Томилолт, зочны зардал	501.6	497.7	3.9	0.6%
11	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,398.1	4,207.7	190.3	4.9%
12	Бараа үйлчилгээний бусад зардал	4,914.1	4,405.4	508.7	5.2%
13	ТАТААС	12.7	12.7	0.0	0.3%
14	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	12.7	12.7	0.0	
15	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,572.4	2,505.9	66.5	2.9%
16	Бусад урсгал шилжүүлэг	2,572.4	2,505.9	66.5	
17	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	34,327.4	30,360.4	3,967.0	35.7%
18	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЗЭЭЛ	2,832.8	1,246.3	1,586.4	1.5%

Тайлант онд батлагдсан төсвийг 8,107.6 сая төгрөгөөр буюу 8.7 хувиар хэмнэжээ. Үүнд: Урсгал зардлыг 2,554.2 сая төгрөг буюу 31.5 хувиар, хөрөнгийн зардлыг 3,967.0 сая төгрөг буюу 48.9 хувиар, эргэж төлөгдөх зээлийн зардлыг 1,586.4 сая төгрөг 19.6 хувиар тус тус хэмнэсэн байна.

Урсгал зардлыг 2,554.2 сая төгрөгөөр хэмнэсэнд цалин, НДШ-ийн зардлыг 9.8 хувиар, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 11.5 хувиар, хангамж, бараа материалын зардлыг 0.2 хувиар, эд хогшил, урсгалын засварын зардлыг 0.6 хувиар, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 2.3 хувиар, бараа үйлчилгээний бусад зардлыг 6.3 хувиар, бусад урсгал шилжүүлгийг 0.8 хувиар хэмнэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Хөрөнгийн зардлыг 3,967.0 сая төгрөгөөр хэмнэсэн нь Орон нутгийн хөрөнгө оруулалт, авто замын сан, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн зарим төсөл арга хэмжээ огт хийгдээгүй, зарим төсөл арга хэмжээ гэрээний хугацаанд бүрэн дуусаагүйгээс санхүүжилт дутуу олгогдсон зэрэгтэй холбоотой байна.

Эргэж төлөгдөх зээлийг 1,586.4 сая төгрөгөөр хэмнэсэн нь ХХС-ийн зээлийг төлөвлөсөн хэмжээнд олгоогүйтэй холбоотой байна.



Нийт зардал өмнөх оноос 27.3 хувиар өссөн нь тайлант онд цалин нэмэгдсэн, орон нутгийн нэмэгдлийг албан хаагчдад 40 хувиар, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгийг төрийн захиргааны албан хаагчдад шинээр олгосон, албан томилолтын тариф халаалтын зардлын үнэ тариф өссөн, 2024 онд аймгийн

ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

төвийн байр ашиглалттай холбоотой тогтмол зардал орон нутгийн төсвөөс санхүүжихээр шийдвэрлэгдсэн, давсан орлогоос Засаг даргын нөөц хөрөнгийг нэмэгдүүлэн зарцуулж байгаа нь голлох нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт 10. Төсвийн гүйцэтгэл хөтөлбөр, арга хэмжээгээр

/сая төгрөгөөр/

Д.д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт хувь
1	70105 ОН-ын өөрөө удирд ёсны байгууллага	5,148.2	4,958.2	190.0	96.3%
2	70106 ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага	41,007.0	38,042.5	2,964.5	92.8%
3	70417 Мэргэжлийн хяналт	442.6	440.1	2.5	99.4%
4	70418 Худалдан авах ажиллагаа	364.3	363.2	1.1	99.7%
5	70426 Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлж	434.9	434.8	0.1	100%
6	70503 Орон нутгийн зорилтот ХОруулалт	20,762.3	18,735.9	2,026.3	90.2%
7	70801 Мал аж ахуйг хөгжүүлэх	580.2	580.2	-	100%
8	71101 Авто зам	825.6	590.5	235.1	71.5%
9	71105 Авто тээврийн хяналт, зохицуулалт	12.7	12.7	-	100%
10	71403 Ойжуулалт	351.7	347.9	3.8	98.9%
11	71411 Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	2,250.1	2,226.0	24.1	98.9%
12	71502 Хот байгуулалт, тохижилт	1,763.9	1,763.9	-	100%
13	71601 Нийгмийн эрүүл мэнд	150.0	150.0	0.0	100%
14	71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ	2,982.1	2,504.3	477.8	84%
15	71701 Биеийн тамир спорт	994.7	894.7	100.0	89.9%
16	71702 Соёл урлаг	1,425.4	1,373.2	52.2	96.3%
17	71801 Сургуулийн өмнөх боловсрол	2,106.6	1,942.3	164.4	92.2%
18	71802 Ерөнхий боловсрол	7,476.2	7,249.2	227.0	97%
19	71804 Мэргэжлийн боловсрол	817.9	810.3	7.5	99.1%
20	71902 Нийгмийн халамж	150.0	150.0	0.0	100%
21	72208 Ахмад настны хөгжил хамгаалал	256.6	212.0	44.6	82.6%
22	72210 Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэлт	2,832.8	1,246.3	1,586.4	44%
Дүн		93,135.8	85,028.3	8,107.6	91.3%

ТЕЗ-ийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг хөтөлбөр, арга хэмжээгээр авч үзвэл нийт гүйцэтгэлийн 5.8 хувийг Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, 44.7 хувийг Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага, 22 хувийг орон нутгийн хөрөнгө оруулалт 2.6 хувийг хүрээлэн буй орчны бодлого удирдлага 2.1 хувийг Хот байгуулалт, тохижилт, бусад 17 хөтөлбөр, арга хэмжээнд 22.7 хувь нь зарцуулагдсан байна.

2.3 Төсвийг үр ашиггүй, хэт үрэлгэн, зориулалт бусаар зарцуулсан зөрчил буурахгүй, жил бүр давтагдан гарч байна.

ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчилд дүн шинжилгээ хийхэд төсвийг үр ашиггүй, хэт үрэлгэн, зориулалт бусаар зарцуулсан 1,718.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.

Хүснэгт 11. Төсвийг үр ашиггүй, зориулалт бус зарцуулсан зөрчил

/сая.төгрөгөөр/

№	Шалгагдагч байгууллагын нэр	Зөрчлийн товч утга	Мөнгөн дүн
1	Улиастай сумын ЗДТГ	Аймгийн Засаг даргын Тамгын газраас аймгийн Засаг даргын 2024 оны А/59 дүгээр захирамжийн дагуу “Дуртмал-Алтан” ХХК-д 44.0 сая төгрөгийг шилжүүлэн 1000 хүний хүлээн авалтыг зохион байгуулан, төсвийг зориулалт бус зарцуулсан байна.	44.0
2	Шилүүстэй сумын ЗДТГ	Засаг даргын нөөц сангийн хөрөнгөөс малчдын зөвлөгөөн зохион байгуулж 12.5 сая төгрөгийн хоол хүнсний материал гаргаж, зориулалт бус зардал гаргасан мөн анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй,	12.5
3	Алдархаан сумын ЗДТГ	Засаг даргын нөөц сангийн хөрөнгийн төлөвлөлт, гүйцэтгэлийг шалгахад Засаг даргын нөөц хөрөнгөөс босоо тогтолцоотой	28.0

ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

		байгууллагын албан хаагч болон Засаг даргын Тамгын газрын албан хаагчид компьютер тоног төхөөрөмж худалдан авч, нөөц сангаас 27,974.3 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн, тусдаа батлагдсан төсөвтэй сумын Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэгийн багш, ажилчдад улс, аймгийн хэмжээнд эрэмбэлэгдсэн байраа ахиулсан гэх үндэслэлээр 10,600.0 мянган төгрөгийн урамшууллыг хавтгайруулан олгосон байна.	
4	Завхан аймгийн ЗДТГ	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-тай байгуулсан санамж бичгийн хүрээнд шилжиж ирсэн 200,000.0 мянган төгрөгийн хандив тусламжийн орлогоос 187,800.0 мянган төгрөгийг аяллын зардалд зориулалт бусаар зарцуулсан.	187.8
5	Түдэвтэй сумын ЗДТГ	Газрын дуудлага худалдааны орлогыг зориулалт бус зарцуулсан	13.6
6	Дөрвөлжин сумын ЗДТГ	Төрийн албан хаагч нарыг аялалд явуулан төсвийн хөрөнгийг үрэлгэн зарцуулсан	20.0
7	Түдэвтэй сумын ЗДТГ	Сумын ИТХ-ын төлөөлөгчдийн тойрогт ажиллах зардлыг төсвөөс гаргасан	2.7
8	Дөрвөлжин сумын ЗДТГ	Төрийн албан хаагчийн урлаг спортын наадам зохион байгуулж зардлыг зориулалт бусаар зарцуулсан	5.0
9	Алдархаан сумын ЗДТГ	Сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс өмнөх оны санхүүгийн тайланд өглөгт тусгаагүйгээр сумын 100 жилийн ойн өр барагдуулсан.	54.5
10	Завхан аймгийн ЗДТГ	Ахмадын баярын үйл ажиллагаанд зориулж хоолны зардал, ТАЗ-д жимсний багц, нутгийн брэнд, байгууллагын албан хаагчдад дархлаа дэмжих витамин, кофе цай худалдан авч, тэмцээний бооцооны мөнгө гаргаж, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан, 2023 оны байгууллагын шилдэг ажилтны шагналд 39,000.0 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж, 2024 оны 02 сард 12 албан хаагчид тус бүр 3.250.0 мянган төгрөгөөр БНХАУ-д аялуулсан.	49.7
11	Баянхайрхан сумын ЗДТГ	Тусдаа батлагдсан төсөвтэй байгууллагад Засаг даргын нөөц хөрөнгөөс ЕБС-ийн сурагчдад "ӨДӨР БҮР СҮҮ" хөтөлбөрийн хүрээнд сүүний төлбөр олгосон	2.0
12	Шилүүстэй сумын ИТХ	Иргэдийн хурлын төлөөлөгч нарт хоол, цайны зардал гаргаж, төсвийг зориулалт бус зарцуулсан	0.7
13	Сонгино сумын ЗДТГ	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас морины гарааны болон сэрвээ хэмжих төхөөрөмж худалдаж авч, сумын 100 жилийн ойн хүрээнд "Эвэнт" арга хэмжээ, сургалт зохион байгуулж батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.	26.5
14	Баянхайрхан сумын ЗДТГ	Засаг даргын нөөц хөрөнгөөс 4 иргэнд өвчний түүх, эмчийн бичиггүй эмчилгээний төлбөр олгосон	4.0
15	Их-Уул сумын ЗДТГ	Аймгийн Орон нутгийн хөгжлийн сан, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө, авто замын сангаас эрх шилжсэн хөрөнгөөс хүнсний материал болон хоолны зардал гаргаж, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан.	11.1
16	Улиастай сумын ИТХ	Байгууллагын шатахууны зардлыг талонаар зарцуулж байгаа нь тус зардлыг зориулалт бусаар үрэлгэн зарцуулах эрсдэлийг үүсгэж байна.	-
17	Улиастай сумын ИТХ	Сумын ИТХ-ын 7 төлөөлөгчид үйл ажиллагааны зардал тус бүр 1.200.0 мянган төгрөг олгож, зардлыг зориулалт бусаар зарцуулсан байна.	8.4
18	Яруу сумын ИТХ	Төсвөөс хуралдаан хийх бүртээ 15-40 тэмдэглэлийн дэвтэр, бал, хүнсний материалыг худалдан авч 6.7 сая төгрөгийн зориулалт бус, үрэлгэн зардал гаргасан байна.	6.7
19	Идэр сумын ЗДТГ	Газрын дуудлага худалдааны орлогыг зориулалт бусаар зарцуулсан	6.9
20	Завханмандал сумын ЗДТГ	Говийн бүсийн уралдаан, үндсэн хуулийн өдөрт зориулсан бөхийн барилдаан зэрэг спортын арга хэмжээг санхүүжүүлж шагналын зардал гаргасан	5.6
21	Нөмрөг сумын ИТХ	Төсвийн хөрөнгөнөөс батлагдсан төсөвтэй байгууллагын ойн арга хэмжээнд дэмжлэг олгож төсвийг зориулалт бусаар зарцуулсан	15.0

ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

22	Их-Уул сумын ИТХ	Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга Бүгд Найрамдах Солонгос улсад туршлага судлах сургалтын зардал гаргаж, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.	3.5
23	Нөмрөг сумын ЗДТГ	Төсвийн хөрөнгөнөөс батлагдсан төсөвтэй байгууллагын ойн арга хэмжээнд дэмжлэг олгож төсвийг зориулалт бусаар зарцуулсан	13.0
24	Цагаанчулуут сумын ИТХ	Төсвийг зориулалт бусаар зарцуулан хүүхдийн тоглоомын талбайд тоглоом худалдаж авсан	10.0
25	Сонгино сумын ЗДТГ	Засаг даргын нөөц хөрөнгөөс сумын 100 жилийн ойн үйл ажиллагааны хүрээнд залуучууд, эмэгтэйчүүдийн уулзалт, эрдэм шинжилгээний бага хурал, урлаг соёлын арга хэмжээний зардал, ойн энгэрийн тэмдэг, хүндэт тэмдэг, 100 жилийн ойн ном сэтгүүлийн үнэ зэрэгт зарцуулсан	70.0
26	Сонгино сумын ЗДТГ	Засаг даргын нөөц хөрөнгөөс сумын 100 жилийн ойн үйл ажиллагааны хүрээнд спортын тэмцээн, спортын бага наадам зохион байгуулан дэмжлэг үзүүлсэн	13.0
27	Яруу сумын ЗДТГ	Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас эрх шилжсэн 20.0 сая төгрөгийн дэмжлэгийг сумын 100 жилийн ойн арга хэмжээний медаль, үнэмлэх, ном хэвлэлийн зардалд 18.5 сая төгрөгийг гарган зориулалт бус зарцуулсан	18.5
28	Отгон сумын ЗДТГ	Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хот, Зүүн хараа, Улиастай сумын нутгийн зөвлөлийн уулзалт, золголт оролцохоор төсвөөс 2,554,200 төгрөгийн шатахуун зарцуулсан байна.	2.6
29	Сонгино сумын ИТХ	ИТХ-н нарийн бичгийн дарга Солонгос улсад туршлага судлах сургалтын зардал гаргасан	3.5
30	Цагаанхайрхан сумын ЗДТГ	Төсвөөс сумын 100 жилийн ойн ном хэвлэх ажилд дэмжлэг үзүүлж зориулалт бусаар зарцуулсан	2.9
31	Цагаанхайрхан сумын ЗДТГ	Залуучуудын чуулга уулзалт, татвар төлөгчдийн өдөр, спортын тэмцээн уралдааны дэмжлэг, шагналын зардал, батлагдсан төсөвтэй байгууллагын ойн арга хэмжээг дэмжиж зориулалт бусаар зарцуулсан	2.2
32	Цагаанхайрхан сумын ИТХ	Төрийн албан хаагчдын зөвлөгөөн, татвар төлөгчдийн өдөр зэрэг арга хэмжээг санхүүжүүлж, тэмцээн уралдааны дэмжлэг, шагналын зардал гаргасан, батлагдсан төсөвтэй байгууллагын ойн арга хэмжээнд дэмжлэг олгосон 1,890.0 мянган төгрөгийн зөрчил байна.	1.9
33	Алдархаан сумын ИТХ	Сумын ИТХ-ын хуралдаанд хоолны зардал гаргаж, төсвийг зориулалт бусаар зарцуулсан.	1.4
34	Алдархаан сумын ЗДТГ	Засаг даргын нөөц хөрөнгөөс тусдаа батлагдсан төсөвтэй сумын Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэгийн багш, ажилчдад улс, аймгийн хэмжээнд эрэмбэлэгдсэн байраа ахиулсан гэх үндэслэлээр 10,600.0 мянган төгрөгийн урамшууллыг хавтгайруулан олгосон байна.	10.6
35	Засаг даргын нөөц хөрөнгө	Засаг даргын нөөц хөрөнгийг хэт үрэлгэн зарцуулсан	579.7
36	Түдэвтэй сум дахь сум дундын ойн анги	Байгууллагын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Дарамсэнгэ нь ажил хавсран гүйцэтгэсэн 40%- ийн цалинг өөрийн механик инженерийн үндсэн цалингаас авсан зөрчил илэрсэн	0.4
37	Завхан аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний хүрээнд онцгой болон, энгийн хамгаалалтын бүсэд хориглосон тэмдэгжүүлэх самбар хийх 18,520.0 мянган төгрөгийн ажлыг дуусгаж хүлээж авсан бөгөөд самбарыг онцгой бүсүүдэд байршуулж, суулгах	18.5
38	Завхан аймгийн ЗДТГ	Дотоод албан томилолтын зардлаас гадаад томилолтын зардал гаргаж, анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлээгүй, аварга малчдын шагнал бэлтгэх, цагаан сарын болон сумдын ойд шагнал гардуулах ажлаар явсан, мөн сонгуулийн саналын хуудас хэвлүүлэх ажлын хэсэгтэй Улаанбаатар хот явсан, баруун бүсийн ЗДТГ-ын албан хаагчдын тэмцээнд оролцохоор явсан албан хаагчдад томилолт олгож, дотоод албан томилолтын зардлыг албан бус хэрэгцээнд хэт үрэлгэн зарцуулсан.	24.3
39	Эрдэнэ хайрхан хөгжил ОНӨҮГ	"Нүүрс тээврийн хөлсийг зах зээлийн ханшнаас 6,987,400 төгрөгөөр хэт өндөр тооцож олгосон.	7.0

ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

40	Тосонцэнгэл сумын ЗДТГ	Албан томилолтоор ажилласан эмч нарт 1,650.0 мянган төгрөгийн хоолны зардлыг зориулалт бус гаргасан байна.	1.6
41	Тосонцэнгэл сумын ЗДТГ	Халаалтын тариф батлагдаагүй байхад нэмэгдсэн тарифаар гэрээ байгуулж халаалтын хөлс өгсөн.	2.80
42	Улиастай сумын ИТХ	Сумын ИТХ-ын дарга хувийн автомашинаар хот дотор өдөр тутам шатахуун үрэлгэн зарцуулсан, ИТХ-ын үйл ажиллагаанд хамааралгүй ажилд шатахуун зарцуулсан	1.6
43	ОЧИР-ИЛЧ ОНӨҮГ	Хот дотор байгууллагын чиг үүрэгт хамааралгүй үйл ажиллагаанд шатахууныг талонаар зарцуулж байгаа нь тус зардлыг хяналтгүй зориулалт бусаар үрэлгэн зарцуулах эрсдэлийг үүсгэж байна.	1.1
44	Завханмандал сумын ЗДТГ	Балансын нэмэгдлийг ЗДТГ-ын даргад олгосон	0.7
45	Аймгийн ОНХС	"Орон нутгийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээс санхүүжүүлэх 3 ажлын 238.0 сая төгрөг, автозамын сангаас санхүүжих 1 ажлын 10.0 сая төгрөгийг АОНХС-ийн хөрөнгөөс санхүүжүүлсэн, ""Жалханз хутагт Ц.Дамдинбазарын дурсгалт цогцолбор байгуулах"" ажлын 300.0 сая төгрөгийн санхүүжилтээс 290.0 сая төгрөгийг олгосон боловч санхүүжилтийн тооцоог зөрүүтэй тооцоолсноос 40.0 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд илүү төвлөрүүлсэн.	288.0
46	Аймгийн ОНХС	Өвөлжилт, хаваржилтын зудын эрсдэлийг даван туулах арга хэмжээний болон аймгийн хэмжээнд шинээр барих барилга байгууламжийн зураг төсөв хийлгэх ажлын санхүүжилтийг батлагдсан төсвөөс 122.8 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.	122.7
47	Дөрвөлжин сумын ИТХ	Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас төлөөлөгчдийн хоол олгосон	1.2
48	Тэлмэн сумын ЗДТГ	Цагдаагийн албан хаагчийн албан ажлын шатахууныг байгууллагаас олгосон	2.0
49	Тэлмэн сумын ЗДТГ	Газрын дуудлага худалдааны орлогыг зориулалт бусаар зарцуулсан	6.6
50	Тэлмэн сумын ОНХС	Төсөвт байгууллагуудын урсгал засварын зардлыг ОНХС-ын төсвөөс гаргасан	1.9
Дүн			1,718.2



2.4 Шат, шатны Засаг даргын нөөц хөрөнгийг орон нутгийн давсан орлогоос нэмэгдүүлэн баталж байгаа нь төсвийг үр ашиггүй үрэлгэн зарцуулах нөхцөлийг бүрдүүлж байна.

Санхүүгийн тайлангийн аудитын 2024 оны ерөнхий чиглэлийн дагуу орон нутгийн төсөвт байгууллагуудаас авсан судалгааны нэгтгэл, дүн шинжилгээ хийсэн байдал:


Ахмадын сан: ТЕЗ-ын харьяа төсөвт 63 байгууллагаас 2 байгууллага Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 243 дугаар тогтоолоор “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ын дагуу ахмадын сангийн үйл ажиллагаа явуулж байна. Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар ахмадын сантай холбоотой зөрчил илрээгүй байна.

Худалдан авах ажиллагаа: Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагууд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу нийт 8,361.2 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээний тендер шалгаруулалт зохион байгуулсан байна. Үүнээс: Харьцуулалтын аргаар 5,271.3 сая төгрөгийн, нээлтэй тендер шалгаруулалтын аргаар 1,862.8 сая төгрөгийн, ерөнхий гэрээний аргаар 18.7 сая төгрөгийн, гэрээ шууд байгуулахаар аргаар 694.8 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааг зохион байгуулжээ. 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчил илрээгүй байна.

Орон тоо: ТЕЗ-ын харьяа төсөвт 63 байгууллагын орон тооны судалгаанд дүн шинжилгээ хийхэд 953 орон тоонд 24,585.3 сая төгрөгийн цалингийн зардал төлөвлөж, гүйцэтгэлээр 940 оронд 23,670.9 сая төгрөгийг зарцуулсан байна. Үүнээс: гүйцэтгэх ажилтан 12, үйлчлэх ажилтан 5 орон тооны хэмнэлт үүсгэснээс гэрээт ажилтан 4 орон тоог нэмж ажилласан байна.



Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал-210801: Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 2024 онд 4,398.1 сая төгрөгөөр төлөвлөж, 4,207.7 сая төгрөг зарцуулж, гүйцэтгэл 95.7 хувьтай байна.




Тус зардлыг өмнөх оноос 1,061.8 сая төгрөгөөр буюу 31.8 хувиар нэмэгдүүлж баталсан байна. Энэ нь АИТХ-д гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардал, Алдархаан сумын ЗДТГ, Тосонцэнгэл сумын ИТХ, ЗДТГ, Улиастай сумын ЗДТГ болон Хот тохижилт үйлчилгээний албанд орон нутгаас олгох санхүүжилт, аймгийн Засаг дарга дансанд Мал эмнэлгийн үйлчилгээний

хөлс, аймгийн Ахмадын хороо, “Баруун бүсийн тамирчдыг олимпод бэлтгэх төв” ОНӨААН-ийн санхүүжилтийг нэмэгдүүлсэн нь голлох нөлөө үзүүлж байна. Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар 210801 зардалтай холбоотой 85.0 сая төгрөгийн зөрчил илэрч, 77.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 7.7 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн байна.

Бараа үйлчилгээний бусад зардал-210901: Бараа үйлчилгээний бусад зардлыг 2024 онд 4,756.4 сая төгрөгөөр төлөвлөж, 4,280.0 сая төгрөг зарцуулж, гүйцэтгэл 90 хувьтай байна.

Тус зардлыг өмнөх оноос 975.3 сая төгрөгөөр буюу 25.8 хувиар нэмэгдүүлэн баталсан байна. Энэ нь шат, шатны Засаг даргын нөөц хөрөнгийг орон нутгийн давсан орлоогоос нэмэгдүүлж баталсан холбоотой байна. Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар 210901 зардалтай холбоотой 1,302.6 сая төгрөгийн зөрчил илэрч, 1,187.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 60.4 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч, 54.5 сая төгрөгийн зөрчлийг хуулийн байгууллагад шилжүүлсэн байна.



ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Урсгал зардлыг нэмэгдүүлэн баталж, зориулалт бусаар зарцуулж байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.2-д “төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх”, 14 дүгээр зүйлийн 14.2-д “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 14.2.2-д “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох”, 14.2-д “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

2.5 ТЕЗ-ийн харьяа байгууллагууд ОНХС-ийн хөрөнгийг урсгал зардал болон журам зөрчсөн төсөл арга хэмжээнд төлөвлөж, зарцуулсан, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ гэрээний хугацаанд хийгдээгүй, бүрэн дуусаагүй 3,766.0 сая төгрөгийн зөрчил байна.

ТЕЗ-ийн харьяа байгууллагуудад Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаатай холбоотой нийт 3,766.0 сая төгрөгийн зөрчил илэрснээс 1,581.1 сая төгрөг нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ гэрээний хугацаанд хийгдээгүй, бүрэн дуусаагүй, 1,808.0 сая төгрөг нь урсгал зардал санхүүжүүлж, журам зөрчсөн төсөл арга хэмжээнд төлөвлөж, зарцуулсантай холбоотой зөрчил байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ гэрээний хугацаанд хийгдээгүй, бүрэн дуусаагүйтэй холбоотой дараах сумдад зөрчил илэрсэн байна. Үүнд:

Хүснэгт 12. ОНХС-ийн зөрчил

/сая.төгрөгөөр/

Байгууллагын нэр	Зөрчлийн утга	Мөнгөн дүн	Аудитын шийдвэр
Отгон сумын ОНХС	Нийтийн 00 барих ажлыг "Цэн эко төгөл" ХХК-аар гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж, 16.0 сая төгрөгийн урьдчилгаа олгосон боловч ажил бүрэн хийгдээгүй байна.	16.0	Албан шаардлага
Улиастай сумын ОНХС	Ширээ ХХК-тай гэрээ байгуулан "Богдын гол багийн гэр хорооллын интернэт сүлжээг сайжруулах" ажлын гэрээний хугацаа дууссан, ажил хүлээлцээгүй, ажлын даалгавар тодорхой бус, хяналт тавиагүй, санхүүжилтийг бүрэн олгосон байна. Алдаржаргал ХХК-тай гэрээ байгуулан "Алслагдсан гэр хороололд гуравласан үйлчилгээг хүргэх дэд бүтцэд дэмжлэг үзүүлэх" ажил гэрээт хугацаандаа хийгдээгүй ажлын тоо хэмжээ тодорхой бус, явцад хяналт хэрэгжүүлээгүй байна.	29.5	Зөвлөмж
Ургамал сумын ОНХС	Бүх нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх спортын талбай байгуулах ажлыг "Их-Хорьдол ХХК"-аар гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж урьдчилгаа санхүүжилт олгосон боловч тус ажлыг гэрээний хугацаанд бүрэн дуусаагүй, хүлээж аваагүй;	111.3	Албан шаардлага
Аймгийн ОНХС	Өвөлжилт хүндэрсэнтэй холбогдуулан өвс худалдаж авахаар "Бат анда ялалт холдинг" ХХК-тай гэрээ байгуулж, 240,000,000 төгрөгийг шилжүүлсэн боловч одоог хүртэл өвс нийлүүлэгдээгүй байна.	240.0	Албан шаардлага
Тосонцэнгэл сумын ОНХС	Тосонцэнгэл сумын Орон нутгийн хөгжлийн сангаас 2023 онд хийхээр төлөвлөсөн Хожуулын голын модон гүүр засварлах ажлын гүйцэтгэгчээр "Завхан АЗЗА" ХХК шалгарч 187,473.0 мянган төгрөгөөр бүрэн засварлаж гүйцэтгэхээр гэрээ байгуулсан боловч тус ажлын тоо хэмжээнд заасны дагуу ажлыг бүрэн хийж гүйцэтгээгүй байна. Мөн 2024 оны СТБ-аар үлдэгдэл ажлыг гүйцэтгээгүй санхүүжилтийг бүрэн авсан байна.	37.5	Хуулийн байгууллагад шилжүүлэх
Түдэвтэй сумын ОНХС	2023 оноос дамжин хийгдэх агаарын 04 шугамын ажлын гүйцэтгэл дутуу	65.0	Албан шаардлага

ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Эрдэнэхайрхан сумын ОНХС	Гэр хороололд дулааны шугам татах, сургуулийн эмч нарын 4 айлын барилгын засвар, хог ялган ангилал сав хийхээр ОНХС-ийн төсвөөс санхүүжилтийг шилжүүлсэн ч гэрээт хугацаанд ажил дуусаагүй	255.5	Зөвлөмж
Тэс сумын ОНХС	Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр сувиллын газрын шовгор барих 15,000,000 төгрөгийн төсөвтэй ажлыг Хилийн цэргийн 0277 дугаар ангиар гүйцэтгүүлэхээр барилгын материалын үнийг Пэси Оасис ХХК-руу санхүүжилтийг шилжүүлсэн ч ажил нь хийгдээгүй байна	10.5	Албан шаардлага
Дөрвөлжин сумын ОНХС	Сумын төвд болон гурван багт шинээр худаг гаргах, 0.4-н цахилгааны шугамын шинэчлэл хийх, хүүхэд хамгааллын кабинет тохижуулах, төвлөрсөн халаалт, цэвэр усны шугамд аж ахуйн нэгж, айл өрхүүдийг холбох салбар шугамын ажлыг хийлгэхээр санхүүжилтийг гүйцэтгэгчид шилжүүлсэн ч гэрээт хугацаанд ажил дуусаагүй	341.6	Албан шаардлага
Алдархаан сумын ОНХС	Багийн төв барих, Соёлын төвийн халаалтыг шинэчлэх ажлын санхүүжилтийн бүрэн олгосон ч гүйцэтгэл дутуу гэрээний хугацаанд ажил бүрэн хийгдээгүй	110.0	Албан шаардлага
Ургамал сумын ОНХС	Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад батлагдаагүй ногоон байгууламж нэмэгдүүлэх ажилд урьдчилгаа санхүүжилт олгож, ажил нь одоог хүртэл эхлээгүй байна.	43.00	Албан шаардлага
Тэс сумын Орон нутгийн хөгжлийн сан	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс төсвөөс сумын Гамшгийн эрсдэлийн санд өвс нөөцлөхөөр иргэн Г.Аюурмөнхийн данс руу өвсний үнийг шилжүүлсэн ч өвс тэжээл нь одоог хүртэл нийлүүлэгдээгүй байна	5.00	Төлбөрийн акт
Улиастай сумын Засаг даргын Тамгын газар	Орон нутгийн замын сангийн санхүүжилтээр "Эко эвсэг зам" ХХК-н гүйцэтгэсэн 79.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Нутгийн удирдлагын ордны зүүн талын зогсоолыг засварлах" ажил 2023-2024 онуудад үргэлжилсэн бөгөөд гэрээний хугацаа дууссан, ажил хүлээлцээгүй, санхүүжилтийг бүрэн олгож, тайлант онд 12.8 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.	12.8	Албан шаардлага
Улиастай сумын Засаг даргын Тамгын газар	Аймгийн Орон нутгийн Хөгжлийн сангаас 300.0 сая төгрөгөөр төлөвлөгдөж эрх шилжсэн ажлын гэрээний дүнг 440.7 сая төгрөгөөр байгуулан "Жалханз хутагт Ц.Дамдинбазар"-ын 150 жилийн ойд зориулж дурсгалт цогцолбор, хөшөө байгуулах ажлыг хийж гүйцэтгэхээр иргэн Ганхуягтай хийсэн гэрээний хугацаа дууссан, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй, ажил хүлээлцээгүй, тайлант онд 275.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.	275.5	Албан шаардлага
Улиастай сумын Засаг даргын Тамгын газар	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр эрх шилжсэн "Энх мөнх ирээдүй" ХХК-н гүйцэтгэсэн 89.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Цэргийн ангийн баруун талаас зүүн чиглэлийн пост хүртэлх явган замыг шинэчлэх" ажил 2023-2024 онуудад үргэлжилсэн бөгөөд гэрээний хугацаа дууссан, ажил хүлээлцээгүй, захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн ч зураг төсөв, техникийн нөхцөлийн дагуу хийж гүйцэтгээгүйн улмаас ажлыг хүлээлгэн өгөөгүй зэрэг зөрчил илэрсэн байна.	28.0	Албан шаардлага
Дүн		1,581.1	

ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

ОНХС-ийн урсгал зардал болон журам зөрчсөн төсөл арга хэмжээнд төлөвлөж, зарцуулсан холбоотой дараах сумдад зөрчил илэрсэн байна. Үүнд:

Хүснэгт 13. ОНХС-ийн зөрчил

/сая.төгрөгөөр/

Байгууллагын нэр	Зөрчлийн утга	Мөнгөн дүн	Аудитын шийдвэр
Улиастай сумын ОНХС	"Жавхлант" сууц өмчлөгчдийн холбоо, МҮХАҮТ, оёдолчдын холбоо зэрэгт санхүүгийн дэмжлэг үзүүлж төсвийг зориулалт бус зарцуулсан	75.5	Албан шаардлага
Завханмандал сумын ОНХС	Байгаль орчныг хамгаалах зорилгоор "Air" телевизээр цаг үеийн мэдээлэл, орон нутгийн ТВ-ийн нэвтрүүлэг, "ЭСГИЙ ТУУРГАТАН" нэвтрүүлэг бэлтгэж TV5, TV2, MINC, 1000 МАЛЧИН, ОРОН НУТАГ ТЕЛЕВИЗ ТАВАН ЭРДЭНЭ, LIKE зэрэг телевизүүдэд төлбөр төлсөн.	14.3	Албан шаардлага
Баянхайрхан сумын ОНХС	Улсын баяр наадмын зардлыг 5,000,000 төгрөгөөр илүү зарцуулсан байна.	5.0	Зөвлөмж
Цэцэн-Уул сумын ОНХС	"Төрийн цогц үйлчилгээг багт хүргэх" ажлыг зохион байгуулан 20.0 сая төгрөгөөр спортын тэмцээн уралдаан, соёл урлагийн арга хэмжээг зохион байгуулан төсвөөс зориулалт бус, үр ашиггүй зардал гаргасан байна.	20.0	Албан шаардлага
Аймгийн Орон нутгийн хөгжлийн сан	Орон нутгийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээс санхүүжүүлэх 3 ажлын 238.0 сая төгрөг, автозамын сангаас санхүүжих 1 ажлын 10.0 сая төгрөгийг АОНХС-ийн хөрөнгөөс санхүүжүүлсэн, "Жалханз хутагт Ц.Дамдинбазарын дурсгалт цогцолбор байгуулах" ажлын 300.0 сая төгрөгийн санхүүжилтээс 290.0 сая төгрөгийг олгосон боловч санхүүжилтийн тооцоог зөрүүтэй тооцоолсноос 40.0 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд илүү төвлөрүүлсэн.	288.0	Албан шаардлага
Аймгийн Орон нутгийн хөгжлийн сан	Өвөлжилт, хаваржилтын зудын эрсдэлийг даван туулах арга хэмжээний болон аймгийн хэмжээнд шинээр барих барилга байгууламжийн зураг төсөв хийлгэх ажлын санхүүжилтийг батлагдсан төсвөөс 122.8 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.	122.8	Албан шаардлага
Тосонцэнгэл сумын ОНХС	Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинээр хийлгэх 58.8 сая, 78.4 сая төгрөг гүйцэтгэлээр өгсөн гэрээний хугацаа 2025.02.05-нд дууссан үлдэгдэл ажил хийгдэж ирээгүй байна.	58.8	Зөвлөмж
Аймгийн Орон нутгийн хөгжлийн сан	Гадаадын улс орнуудтай хамтран олон талт арга хэмжээг зохион байгуулах, гэрээ санамж бичиг байгуулах, Орон нутагт зохион байгуулж буй онцлог үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэдэд сурталчлах, "Өсвөрийн шигшээ баг"-ийг 10 төрлөөр байгуулж, спорт холбоо, сонирхлын бүлгүүдийн үйл ажиллагааг дэмжих, улс, аймгийн аварга малчин шалгаруулж, хүндэтгэл үзүүлэх, Завхан аймаг Тыва Улс хоорондын хамтын ажиллагааны хүрээнд Кызыл хотод арга хэмжээ зохион байгуулах зэрэг ОНХС-ийн журам зөрчсөн арга хэмжээнд төлөвлөж, зарцуулсан.	602.1	Албан шаардлага
Тэлмэн сумын ОНХС	Төсөвт байгууллагуудын урсгал засварын зардлыг ОНХС-ын төсвөөс гаргасан	2.0	Албан шаардлага
Тэлмэн сумын ОНХС	ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр журамд нийцээгүй хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн	10.0	Албан шаардлага
Дөрвөлжин сумын ОНХС	Үндэсний их баяр наадам Ардын хувьсгалын 103 жилийн ой, сумын түүхт 100 жилийн ойн баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлсэн	609.5	Албан шаардлага

ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Улиастай сумын ОНХС	"Жавхлант" сууц өмчлөгчдийн холбоо, МҮХАҮТ, оёдолчдын холбоо зэрэгт санхүүгийн дэмжлэг үзүүлж төсвийг зориулалт бус зарцуулсан	1,808.0	Албан шаардлага
Дүн		1,808.0	

ОНХС-ийн хөрөнгөөр урсгал зардал санхүүжүүлсэн 1,744.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 63.8 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн байна. Харин гэрээний хугацаанд хийгдээгүй, бүрэн дуусаагүйтэй холбоотой 937.4 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 285.0 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж, 5.0 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн азт, 37.5 сая төгрөгийн зөрчлийг хууль, хяналтын байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Гүйцэтгэлээр 14,095.3 сая төгрөгийг зарцуулж, 3,766.0 сая төгрөгийн зөрчил гарсан нь нийт гүйцэтгэлийн 26.7 хувийг эзэлж байна.

Иймд аймаг, сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлэх, гүйцэтгэлийг хангаж ажиллахад анхаарч, хөрөнгө оруулалтын ажлуудад тавих шат, шатны хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Аудитын илрүүлэлт:
 Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүй зөрчил давтагдан гарч байгаад албан шаардлага өгөхөөр шийдвэрлэлээ.

Хоршоо хөгжүүлэх сан

Хоршоо хөгжүүлэх сангийн орлогыг 2,833.8 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 1,832.7 сая төгрөгийн орлого төвлөрч, орлогын төлөвлөгөө 1,000.1 сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт гэрээний хугацаанд төлөгдөөгүйтэй холбоотой байна.

Хүснэгт 14. Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн авлага

/сая.төгрөгөөр/

д/д	Сумын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
1	Алдархаан	196.7	244.9	(48.3)	124%
2	Асгат	169.7	158.6	(11.1)	93%
3	Баянтэс	159.3	147.3	(12.1)	92%
4	Баянхайрхан	188.7	155.2	(33.5)	83%
5	Дөрвөлжин	165.8	58.1	(107.7)	35%
6	Завханмандал	170.3	126.3	(44.1)	74%
7	Идэр	181.2	178.2	(3.1)	98%
8	Их-Уул	280.4	285.2	4.9	101%
9	Нөмрөг	169.5	177.6	8.0	104%
10	Отгон	188.0	86.2	(101.8)	46%
11	Сантмаргаз	130.9	161.3	30.4	123%
12	Сонгино	130.7	105.4	(25.4)	80%
13	Тосонцэнгэл	473.4	558.5	85.1	118%
14	Тэс	181.6	94.6	(87.1)	52%
15	Түдэвтэй	191.4	193.1	1.7	101%
16	Тэлмэн	167.7	89.0	(78.7)	53%
17	Улиастай	808.7	785.6	(23.1)	97%
18	Ургамал	112.4	79.2	(33.2)	70%
19	Цэцэн-Уул	192.8	170.7	(22.1)	89%
20	Цагаанхайрхан	151.0	128.3	(22.7)	85%
21	Цагаанчулуут	226.8	215.1	(11.7)	95%
22	Шилүүстэй	200.9	176.1	(24.7)	88%

ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

23	Эрдэнэхайрхан	218.1	157.3	(60.8)	72%
24	Яруу	154.2	205.2	51.1	133%
Нийт дүн		5,210.0	4,736.7	(473.3)	91%

Хоршоо хөгжүүлэх сангийн авлага өмнөх оноос 473.3 сая төгрөгөөр буурсан байна. Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар 11 сумын Хоршоо хөгжүүлэх санд 490.0 сая төгрөгийн зөрчил илэрснээс 222.8 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж, 267.2 сая төгрөгийн зөрчлийг хуулийн байгууллагад шилжүүлсэн байна. Гүйцэтгэл бүрэн хангагдахгүй байгаа нь сумдад шаардлага хангасан хоршоо оролцдоггүйгээс шалтгаалж байна.

Засаг даргын ерөнхий дансны төлөвлөлт, зарцуулалт: Засаг даргын ерөнхий дансанд 2024 онд 6 хөтөлбөр, арга хэмжээнд 2,763.9 сая төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 2,307.8 сая төгрөг зарцуулсан байна. Үүнд:

- 70106-Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөр, арга хэмжээнд 17.7 сая төгрөг;
- 70801-Мал аж ахуйг хөгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд 580.2 сая төгрөг;
- 71101-Авто зам хөтөлбөр, арга хэмжээнд 590.5 сая төгрөг;
- 71105-Авто тээврийн хяналт, зохицуулалт хөтөлбөр, арга хэмжээнд 12.7 сая төгрөг;
- 71701-Биеийн тамир спорт хөтөлбөр, арга хэмжээнд 894.7 сая төгрөг;
- 72208 Ахмад настны хөгжил хамгаалал хөтөлбөр, арга хэмжээнд 212.0 сая төгрөг тус тус зарцуулжээ.

Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсээс Засаг даргын ерөнхий дансыг төсвийн төлөвлөлттэй холбоотойгоор бий болсон гэх тайлбарыг өгсөн боловч тус дансаар зарцуулалт хийх хууль, журмын зохицуулалт байхгүй байна. Иймд Засаг даргын ерөнхий дансны зарцуулалтыг тодорхой болгох, эрх зүйн зохицуулалт хийх шаардлагатай байна. Тус дансанд урсгал зардал төлөвлөж, ТББ-д дэмжлэг олгосон зөрчилд ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгсөн байна.

Нэмэлт төсвийн гүйцэтгэл

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтээр дээд шатны төсөв захирагчаас 6 байгууллага 3,072.9 сая төгрөгийн, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 24 байгууллага 6,346.7 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ. Үүнээс цалин, нийгмийн даатгалын шимтгэл, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж, бараа материал, эд хогшил урсгал засвар, дотоод албан томилолт, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж, бараа үйлчилгээний бусад зардал, нэг удаагийн тэтгэмж урамшуулал зэрэг урсгал зардалд 8,362.1 сая төгрөгийг зарцуулж, зарцуулагдаагүй үлдэгдэл 1,057.5 сая төгрөгийг аймгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

БҮЛЭГ 3. АЙМГИЙН 2024 ОНЫ ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНӨӨС ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ ХАСАЖ, УРСГАЛ ЗАРДЛЫГ 135.4 САЯ ТӨГРӨГӨӨР САНХҮҮЖҮҮЛЭХЭЭР ТОДОТГОН БАТАЛЖЭЭ.

3.1 Хөрөнгө оруулалтын төсвийг зохистой, үр дүнтэй удирдаж, гүйцэтгэлийг бүрэн хангаж ажиллах шаардлагатай байна.

Завхан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдааны 2023 оны 93 дугаар тогтоолоор аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөг баталж, 16 зорилтын хүрээнд 252 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнд:

- Хүний хөгжлийн бодлогын хүрээнд 25 арга хэмжээ
- Эдийн засгийн хөгжлийн бодлогын хүрээнд 15 арга хэмжээ
- Засаглалын бодлогын хүрээнд 24 арга хэмжээ
- Ногоон хөгжлийн бодлогын хүрээнд 6 арга хэмжээ
- Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын хүрээнд 182 арга хэмжээ тус тус байна.

Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 252 төсөл арга хэмжээнээс 217 төсөл арга хэмжээнд үнэлэлт дүгнэлт өгснөөс дараах 4 ажил тэг хувьтай байна.

1. Цэцэрлэгийн барилга, 150 ор /Завхан, Улиастай сум/- ТХААГ-т 2024.11.27-ны өдөр тендер нээсэн;
2. Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн улсын чанартай төв хатуу хучилттай авто замаас Идэр сум хүртэлх хатуу хучилттай авто зам, 12.06 км /Завхан,Идэр сум/- ТХХАГ-т 8 удаа тендер зарлаж амжилтгүй болсон;
3. Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станц төслийн цахилгаан хангамж, дэд бүтэц /Завхан, Улиастай сум/- Эрчим хүчний яаманд ХАА зарлагдаж 2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр нээсэн боловч амжилтгүй болсон.Төсөв шинэчлэн Эрчим хүчний үндэсний төвд магадлалаар орж дахин тендер зарлуулахаар Эрчим хүчний яаманд хүсэлт хүргүүлсэн.
4. Тосонцэнгэл сумын нэгдүгээр сургуулийн барилгын их засварын ажлыг дуусгах- 2024 онд санхүүжилт батлагдаагүй тул хүлээгдэж байна гэсэн үндэслэлтэй ажлууд хийгдэж эхлээгүй байна.

Завхан аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөний биелэлтийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдааны 2024 оны 12 дугаар тогтоолоор 217 арга хэмжээний хүрээнд 92.3 хувийн биелэлттэй буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэжээ.

Аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнөөс аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 10 дугаар тогтоолоор тодотгол хийж, төсөв хүрэлцээгүй гэх үндэслэлээр 40 төсөл арга хэмжээг хассан байна. Үүнд:

1. “Тэсийн голын нүүдэлчид” соёлын их наадам зохион байгуулах;
2. Хамтарсан багийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;
3. Насанд хүрээгүй хүүхэд гэрч, хохирогч болсон тохиолдолд өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх;
4. Газар тариалангийн бүс нутгийн судалгаа хийх ;
5. “Отгонтэнгэр”-ийн аялал жуулчлалын мастер төлөвлөгөө боловсруулах;
6. Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн үзлэг зохион байгуулах;
7. Улиастай сумын Жинст багт байрлах Цагдаагийн газрын харьяа конторын барилгад засвар хийх;
8. Улиастай сумын Чигэстэй багийн “Амь-Ус” ХХК-ийн харьяа халуун усны төвлөрсөн дулаан, цэвэр усны шугамд холбож ухаалаг худгийн төхөөрөмж суурилуулах;
9. Тэлмэн сумын жишиг хороололд 0.4 кв-ын 4 км ЦДАШ-ын өргөтгөл хийх;
10. Баянхайрхан сумын Соёлын төвийн барилгад их засвар хийх;
11. Баянхайрхан сумын төвийн зарим хэсгийн 0.4 кв-ын ЦДАШ-ыг шинэчлэх;
12. Баянхайрхан сумын гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх;
13. Их-Уул суманд “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ий хүрээнд ойжуулах, ой нөхөн сэргээх ажил хийх;
14. Завханмандал сумын төвд халуун усны барилга барих

15. Идэр сумын сургуулийн 60 хүүхдийн дотуур байрын барилгад их засвар хийх
16. “Ид шидийн орон” байгуулахад дэмжлэг үзүүлэх
17. Улиастай сумын Жаргалант багийн Алтангийн хэсгийн тоглоомын талбайг тохижуулах;
18. Улиастай сумын Богдын гол багийн гэр хороололд нарны эх үүсгүүртэй гэрэлтүүлэг хийх;
19. Цэргийн ангийн зүүн уулзвараас “Магнай трейд” шатахуун түгээх станц хүртэл дугуйн зам хийх;
20. Асгат сумын ЕБС-д компьютерын лаборатори байгуулах;
21. Асгат сумын хөдөөгийн багуудыг хадлангийн иж бүрэн тоног төхөөрөмжтэй болгох;
22. Асгат сумын халуун усыг засварлаж ахуй үйлчилгээний төв болгох;
23. Цэцэн-Уул суманд аймгийн залуу малчдын чуулга уулзалт зохион байгуулах;
24. Сонгино сумын Бор өндөр багийн шинэ хорооллын цахилгаан хангамжийг сайжруулах;
25. МУ-ын Ардын багш, гавьяат дасгалжуулагч Х.Намширын нэрэмжит “Чөлөөт бөхийн” олон хотын тэмцээн зохион байгуулах;
26. Их-Уул суманд аялал жуулчлалын отог байгуулах;
27. Тэлмэн сумын сургуульд тоглоомын талбай байгуулах;
28. Дөрвөлжин суманд мал нядалгааны цех байгуулах;
29. Дөрвөлжин суманд мал нядалгааны цехэд гүний худаг гаргаж ЦДАШ татах;
30. Улиастай сумын Чигэстэй голын гүүрнээс Цагдаагийн газрын урд байрлах пункт хүртэлх төв цэвэр, бохир усны шугамыг засварлах;
31. Эрдэнэхайрхан сумын ундны усны эх үүсвэрт цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулах;
32. Эрдэнэхайрхан сумын гэр хороололд цэвэр ус, дулааны шугам татах;
33. Их-Уул сумын хүний хөгжлийн ордонг тоног төхөөрөмжөөр хангах;
34. Богдын гол багийн орон сууцуудын гадна талд даацын хавтангаар авто зогсоол хийх /Цагдаагийн 24 айл, Хөгжим бүжгийн 24 айл, 18-н айлын байр/
35. Улиастай сумын Богдын гол багийн 10, 18-р ус түгээх байрыг халаалт, цэвэр усны шугамд холбох;
36. Улиастай сумын “Мичид” кино театрыг орон нутгийн өмчид авсантай холбогдуулан засварлах;
37. Ургамал сумын Хүнгийн голын гүүрийг засварлах;
38. Ургамал суманд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд ногоон төгөл бий болгох;
39. Түдэвтэй сумын ЭМТ-ийн барилгад их засвар хийх;
40. Улиастай сумын Өлзийт багийн өгөөмөр хэсэгт хүүхдийн тоглоомын талбай байгуулах;

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 10 дугаар тогтоолоор нэмж тусгасан төсөл арга хэмжээний жагсаалт:

1. Хил дагуу хамгаалалтын камер суурилуулах;
2. Үндэсний их баяр наадам Ардын хувьсгалын 103 жилийн ой, Завхан аймаг үүсэн байгуулагдсаны 101 жилийн ойг тэмдэглэх ажлын нэмэлт санхүүжилт;
3. Аймгийн өвс тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэх;
4. Аймгийн бодлогын баримт бичиг боловсруулах зөвлөх үйлчилгээ;
5. Завхан аймаг Тува Улс хоорондын хамтын ажиллагааны хүрээнд Кызыл хотод арга хэмжээ зохион байгуулах;
6. Их-Уул суманд тохижилт үйлчилгээний ковш авах;
7. 2023-2024 оны Өвөлжилт, хаваржилтын зудын эрсдэлийг даван туулах;

Аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөнөөс төсөв хүрэлцэхгүй гэх шалтгаанаар хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг хасаж, урсгал зардлын шинжтэй 4 төсөл арга

хэмжээг нэмж баталсан нь хөрөнгө оруулалтын зардлыг зориулалтын дагуу төлөвлөхгүй, төсвийг зохистой, үр дүнтэй удирдахгүй байгааг харуулж байна.

БҮЛЭГ 4. ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.

4.1 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил өмнөх оноос 676.9 сая төгрөгөөр өссөн байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/59 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэл”, А/89 дүгээр тушаалаар баталсан “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”-ын хэрэгжилтийг төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын хүрээнд үзэхэд Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөн 771.8 сая төгрөгийн зөрчил илэрснээс 15.2 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж, 1.7 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 754.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн байна.

Хүснэгт 15. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зөрчил

/сая.төгрөгөөр/

№	ТХТХ-н заалт	Мөнгөн дүн	Зөрчил гаргасан товч утга	Аудитын шийдвэр
1	5.3	1.6	Зөвлөхийн орон тоо бий болгож зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс гэсэн зардлаас цалинжуулсан	Албан шаардлага
2	6.1	11.3	Автомашин ашиглах эрхгүй албан тушаалтан хот дотор болон албан бус ажилд автомашин ашиглаж, шатахуун зарцуулсан.	Зөвлөмж
3	8.1	2.4	Албан хаагчдад хээрийн дадлагын хувцас худалдан авч өгсөн	Албан шаардлага
4	13.3.1	300.0	Жалханз хутагт Ц.Дамдинбазарын 150 жилийн ойд зориулж дурсгалт цогцолбор байгуулах нэрийн дор 300,000,000 төгрөгөөр хөшөө барих ажлыг төлөвлөж, санхүүжүүлсэн байна	Албан шаардлага
5		20.0	ОНХС-ийн төсвөөр угтах, үдэх хаалга хийсэн	Албан шаардлага
6	15.1.3	10.9	Хөдөлмөрийн дотоод журамд заасан гэх үндэслэлээр насны ой, шинэ гэр бүл, шинээр хүүхэд төрөх, сэвлэг үргээх ёслол, 0-18 насны хүүхэдтэй албан хаагчид тэтгэмж олгосон	Албан шаардлага
7		6.9	Засаг даргын нөөц хөрөнгөөс батлагдсан төсөвтэй буюу сумын соёлын төвд дэмжлэг үзүүлсэн, халуун усны барилгын цахилгааны төлбөр төлсөн, цагдаагийн байранд засвар хийсэн байна.	Албан шаардлага
8		35.4	Засаг даргын нөөц хөрөнгөөс батлагдсан төсөвтэй байгууллагуудад, шашны байгууллагад дэмжлэг олгосон	Албан шаардлага
9	15.1.4	15.0	Иргэдэд сум орон нутгаа танилцуулах видео контент хийсэн	Албан шаардлага
10		10.0	Татварын давсан орлогоос телевизийн нэвтрүүлэг бэлтгэсэн	Албан шаардлага
11		0.7	Видео контент бэлтгэсэн	Албан шаардлага
12		19.9	Аймгийн ОНХС-аас эрх шилжсэн хөрөнгөөс сумын 100 жилийн арга хэмжээний нээлт, хаалт дамжуулах телевизийн төлбөр төлсөн	Албан шаардлага
13	15.1.4	14.3	Байгаль орчныг хамгаалах зорилгоор "Air" телевизээр цаг үеийн мэдээлэл, орон нутгийн ТВ-ийн нэвтрүүлэг, "ЭСГИЙ ТУУРГАТАН " нэвтрүүлэг бэлтгэж TV5, TV2, MINC, 1000 МАЛЧИН, ОРОН НУТАГ ТЕЛЕВИЗ ТАВАН ЭРДЭНЭ, LIKE зэрэг телевизүүдэд төлбөр төлсөн.	Албан шаардлага

ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

14		20.0	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс сумын 100 жилийн ойн баяр наадмын шууд дамжуулалтын телевизийн төлбөрт 20.0 сая төгрөг зарцуулж, орон нутгийн хөгжлийн сангийн чиг үүрэгт хамаарахгүй, журам зөрчсөн арга хэмжээ санхүүжүүлсэн;	Албан шаардлага
15	15.1.5	3.9	Төсвөөс шинэ жилийн арга хэмжээнд хөрөнгө зарцуулсан байна.	Зөвлөмж
16		1.9	ОНХС-ийн төсвөөс хээрийн дадлагын хувцас худалдан авсан	Албан шаардлага
17		15.0	ОНХС-ийн төсвөөс 100 жилийн ойн номын эх бэлтгэсэн	Албан шаардлага
18		15.8	АОНХС-аас эрх шилжсэн 16,000.0 мянган төгрөгийн санхүүжилтээс БНСУ-ын КАНВОН Мужийн КАННЫН хоттой байгуулсан гэрээний дагуу ирсэн зочдын буудлын төлбөр, хоолны зардал, бэлэг дурсгалын зүйл худалдаж авахад 15.841.3 мянган төгрөг зарцуулсан	Албан шаардлага
19		1.1	Бэлэг дурсгалын зүйлс худалдан авсан	Төлбөрийн акт
20		0.4	Төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авсан	Төлбөрийн акт
21	15.1.7	0.2	Архи согтууруулах ундаа худалдаж авсан.	Төлбөрийн акт
22		265.1	Засаг даргын нөөц хөрөнгийг	Албан шаардлага
Дүн		771.8		

Дээрх зөрчлийг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн заалтаар харуулбал:

- ✓ 5 дугаар зүйлийн 5.3 дахь заалтыг зөрчин аймгийн ИТХ нь зөвлөхийн орон тоо бий болгож 1.6 сая төгрөгөөр цалинжуулсан;
- ✓ 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтыг зөрчин автомашин ашиглах эрхгүй албан тушаалтан хот дотор болон албан бус ажилд автомашин ашиглан 11.3 сая төгрөгийн шатахуун зарцуулсан;
- ✓ 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалтыг зөрчин Идэр сумын ЗДТГ нь төсвийн хөрөнгөөр 2.4 сая төгрөгөөр дүрэмт хувцас худалдан авсан;
- ✓ 13 дугаар зүйлийн 13.3.1 дэх заалтыг зөрчин аймгийн ОНХС-н хөрөнгөөс 300.0 сая төгрөгийн хөшөө дурсгал босгохоор төлөвлөж, гүйцэтгүүлэхээр эрх шилжүүлсэн, Дөрвөлжин сумын ОНХС-н хөрөнгөөр 20.0 сая төгрөгийн угтах, үдэх хаалга хийсэн;
- ✓ 15 дугаар зүйлийн 15.1.3, 15.1.4, 15.1.5, 15.1.7 дахь заалтуудыг зөрчин тэтгэмж, дэмжлэг олгосон, телевизийн нэвтрүүлэг, контент, сурталчилгаа хийсэн, бэлэг дурсгалын зүйл худалдан авсан зөрчилд 753.3 сая зөрчил гаргасан;



ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Тайлант оны зөрчлийг өмнөх онтой харьцуулахад төлбөрийн акт 12.2 сая төгрөг, зөвлөмж 14.0 сая төгрөгөөр буурч, албан шаардлага 703.1 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 16. ТХТХ-ийн зөрчил

/сая.төгрөгөөр/

Он	Акт		Албан шаардлага		Зөвлөмж		Нийт тоо	Нийт мөнгөн дүн
	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн		
2023	7	13.9	13	51.8	6	29.2	26	94.9
2024	3	1.7	16	754.9	2	15.2	21	771.8
Зөрүү	4	-12.2	-3	703.1	4	-14.0	5	676.9

Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хэмнэлтийн горимд шилжүүлсэн зардлуудын гүйцэтгэлийг авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

Цалин, НДШ-ийн зардал: Цалин, НДШ-ийн зардлыг 25,191.2 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 24,399.7 сая төгрөгийг зарцуулж, 791.5 сая төгрөгөөр буюу 3.1 хувиар хэмнэсэн байна.

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал: Төсөвт байгууллагуудын байр ашиглалттай холбоотой зардлыг 16,150.4 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 15,221.8 сая төгрөг зарцуулж, 928.6 төгрөг буюу 5.7 хувиар хэмнэсэн байна. Тогтмол зардлыг 928.6 сая төгрөгөөр хэмнэсэн боловч улсын төсөвт байгууллагууд 192.1 сая төгрөгийн халаалтын зардлын өглөгтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасантай нийцэхгүй байна.

Бичиг хэргийн зардал: Бичиг хэргийн зардлыг анх 141.9 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 149.1 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 7.2 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.4 “бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх зэргээр бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зардлыг хэмнэх” гэсэн заалтыг хангахгүй байна.

Тээвэр, шатахууны зардал: Тайлант онд тээвэр, шатахууны зардлыг 767.9 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 755.9 сая төгрөг зарцуулж, зардлыг 12.0 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Томилолтын зардал: Томилолтын зардлыг тайланд онд 501.6 сая төгрөгөөр баталснаас 497.7 сая төгрөгийг зарцуулж, 3.9 сая төгрөгийг хэмнэжээ.

Урсгал шилжүүлэг: Бусад урсгал шилжүүлгийг 2,572.4 сая төгрөгөөр төлөвлөж, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж 150.0 сая төгрөг, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулалд 246.8 сая төгрөг, тэтгэвэр гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжид 530.2 сая төгрөг, нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардалд 104.0 сая төгрөг хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжид 1,474.9 сая төгрөг зарцуулж, 66.5 сая төгрөг хэмнэжээ.

4.2 Орон нутгийн өмчит байгууллагуудын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй тээврийн хэрэгслийг 4 удаагийн дуудлага худалдаа зохион байгуулж, орон нутгийн төсөвт 64.2 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг дараах байдлаар ханган ажилласан байна. Үүнд:

Нэг. Хөрөнгийн бүртгэлийн талаар: Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө, орон нутгийн хөгжлийн сан, гадаадын зээл тусламж, хандиваар бий болсон хөрөнгийг бүртгэх ажлыг ОНӨГ нь тухай бүр зохион байгуулж дараах хөрөнгийг бүртгэлд тусгуулан ажилласан байна.

1. ХХААЯамнаас хэрэгжүүлж буй “Шинэ хөдөө” төслийн хүрээнд 11 сумд хадлангийн иж бүрэн тоног төхөөрөмж нийт 2.5 тэрбум төгрөг,
2. Уур амьсгалын өөрчлөлт “ADAPT” төслийн хүрээнд Алдархаан, Шилүүстэй сумдад хөргүүртэй контейнер 410.2 сая төгрөг
3. 16 сумд инженерийн хийцтэй гүн өрмийн худаг 631.9 сая төгрөг
4. Орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн 6.4 тэрбум төгрөг

Хоёр. Хөрөнгийн ашиглалт зохицуулалтын талаар:

Дуудлага худалдаа:

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй-1, Аймгийн Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй-2, нийт 3 үл хөдлөх хөрөнгө (орон сууц)-ийн нээлттэй дуудлага худалдааг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулан төсөвт 360.6 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.
2. 2024 оны Аймгийн ИТХ-ын шийдвэрээр орон нутгийн өмчит байгууллагуудын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй тээврийн хэрэгслийг 4 удаагийн дуудлага худалдаагаар зохион байгуулж, орон нутгийн төсөвт 64.2 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд орон нутгийн өмчит байгууллагаас татан төвлөрүүлсэн автомашиныг цаашид зайлшгүй шаардлагатай байгаа орон нутгийн өмчит хуулийн этгээдэд шилжүүлэх ажлын хүрээнд:

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын “Үндсэн хөрөнгө (автотээврийн хэрэгсэл) балансаас баланст шилжүүлэх тухай” 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/03, 09 дүгээр сарын 19-ний өдрийн А/30, 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/44 дүгээр захирамжийн дагуу нийт 5 автотээврийн хэрэгслийг Яруу сумын ЗДТГ, Дөрвөлжин сумын ИТХ, Шилүүстэй сумын ЕБС, Сонгино ЕБС, Тэсийн ЕБС-д шилжүүлсэн байна.
2. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын “Дуудлага худалдаа зохион байгуулах тухай” 2024 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн А/07, 05 дугаар сарын 30-ны өдрийн А /31, 09 сарын 19-ны өдрийн А/ 31 дүгээр захирамжийг гаргуулж, нийт 14 байгууллагын 25 автотээврийн дуудлага худалдааны захирамж гарсан боловч үүнээс 1 байгууллагын 2 автотээврийг балансаас баланст шилжүүлсэн, 1 автотээврийг ашиглалтын гэрээ байгуулсан байна.

4.3 Шилэн дансны цахим хуудаст тавигдах мэдээллийг журмын дагуу тогтоосон хугацаанд нийтэд мэдээлсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Завхан аймгийн Засаг даргын 2024 оны шилэн дансны цахим системд байршуулсан мэдээллийг шалгахад мэдээлбэл зохих 157 мэдээллээс 135 мэдээллийг

ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

хугацаанд нь, 20 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 2 мэдээллийг байршуулах хуулийн хугацаа болоогүй байна.

Хүснэгт 17. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны мэдээлэл	Нийт мэдээлбэл зохих	Хугацаандаа мэдээлсэн	Хугацаа хоцорсон	Хугацаа болоогүй
Төсөв гүйцэтгэл	81	66	15	
Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт	27	23	4	
Бусад	49	46	1	2
Нийт	157	135	20	2

Шилэн дансны цахим системд оруулах мэдээллийн хугацаа хоцролтын хэрэгжилт 88.3 хувьтай, мэдээлсэн байдлын хэрэгжилт 100 хувьтай байна.

БҮЛЭГ 5. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.

5.1 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 83.3 хувьтай байна.

Завхан аймгийн Засаг даргын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар 4,753.1 сая төгрөгийн зөвлөмж, 114.8 сая төгрөгийн албан шаардлагыг холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын СТСХ нь өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг гаргаж, хэлтсийн даргаар батлуулан, зөвлөмжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжилтийг 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 7/1300 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг гарсан зөрчилтэй харьцуулан үнэлэхэд зөвлөмжийн биелэлт 83.3 хувьтай байна.

Хүснэгт 18. Өмнөх оны шийдвэрийн хэрэгжилт

№	Аудитаар өгсөн зөвлөмж	Байгууллагаас ирүүлсэн албан бичгийн утга, биелэлт	
		Сумдын Засаг дарга нарт	
1	Хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгийг бодитой төлөвлөж, зээлийн эргэн төлөлтийг хуваарийн дагуу гэрээний хугацаанд төлүүлэх, хугацаа хэтэрсэн зээлийг барагдуулах арга хэмжээ авч ажиллах	Байгууллагаас ирүүлсэн тайлбар	2024 онд хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгийг төлөвлөхдөө зээлийн эргэн төлөлтийг бодитой төлөвлөж орлогыг хэт өндөр дүнгээр өсгөхгүй байх талаар сумдын санхүүгийн албаны дарга нарт үүрэг чиглэл өгсөн. Мөн сумдаас ирүүлсэн биелэлт нь хууль, хяналтын байгууллагуудад шилжүүлсэн нотлох баримтууд, тайлант онд хоршоонд олгосон зээлийн нотлох баримтууд, үйл ажиллагааны тайлан, гүйцэтгэлийг ирүүлсэн байна.
		Аудитаар тооцсон биелэлт	ХХС-ийн 2024 оны үйл ажиллагааны тайлан, хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй иргэдийг хууль, хяналтын байгууллагад хүргүүлсэн баримт бичгүүдийг үндэслэн ирүүлсэн байна. Хэрэгжилт-100%
2	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний гэрээний хугацааг	Байгууллагаас ирүүлсэн тайлбар	ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хийгдсэн хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр арга хэмжээний ажлын гэрээ, гүйцэтгэл, ажил хүлээлцсэн актууд

ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

	тухайн төсөл арга хэмжээ хэрэгжих боломжтой, дулааны улиралд гүйцэтгэхээр төлөвлөн байгуулж, төсөл арга хэмжээг чанартай, үр дүнтэй хэрэгжүүлж, гүйцэтгэлийг бүрэн хангаж ажиллах	Аудитаар тооцсон биелэлт	Хэрэгжилт-100%
3	Тусгай сангуудын төлөвлөлтийг бүрэн хангаж, үйл ажиллагааны хэрэгжилт, гүйцэтгэлд хяналт тавьж, арга зүйгээр хангаж ажиллах	Байгууллагаас ирүүлсэн тайлбар	Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хийгдсэн хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр арга хэмжээний ажилд хийгдсэн хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө, тайлан ирүүлсэн.
		Аудитаар тооцсон биелэлт	Тусгай сангуудад хяналт тавьсан тайлан зарим сумд ирүүлээгүй байна. Хэрэгжилт-50%

№	Аудитаар өгсөн албан шаардлага	Байгууллагаас ирүүлсэн албан бичгийн утга, биелэлт	
	Завхан аймгийн Засаг даргад		
1	Орлогын гүйцэтгэлийн тайланг татварын албаны мэдээнээс 114.8 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан, татварын орлогын мэдээнээс 10 нэр төрөлд зөрсөн зөрчил давтагдан гарсан байна.	Байгууллагаас ирүүлсэн тайлбар	Татварын орлогын гүйцэтгэлийг татварын байцаагч нартай тулган баталгаажуулан бүртгэдэг боловч төрийн сангийн программд гүйцэтгэлийг оруулахдаа өөр нэр төрлөөр хаах тохиолдол байдаг. Иймд 2024 онд аймгийн татварын газраас сар улирлын мэдээг сумаар гаргуулан тулган баталгаажуулж байна.
		Аудитаар биелэлт	тооцсон Хэрэгжилт-100 хувь

ДҮГНЭЛТ

1. Орон нутгийн татварын орлого төлөвлөгөөнөөс давж биелсэн боловч 7 нэр төрлийн орлого тасарсан байна.
2. Орон нутгийн 2024 оны төсвийн нийт зардалд эзлэх урсгал зардлын хэмжээ өмнөх оноос 41.3 хувиар өссөн нь төсвийн үр ашгийг дээшлүүлэх бодлоготой уялдахгүй байна. Төсвийг үр ашиггүй, үрэлгэн, зориулалт бусаар зарцуулсан зөрчил буурахгүй давтагдан гарч байна.
3. Шат, шатны Засаг даргын нөөц хөрөнгийг орон нутгийн давсан орлогоос нэмэгдүүлэн баталж байгаа нь төсвийг үр ашиггүй үрэлгэн зарцуулах нөхцөлийг бүрдүүлж байна.
4. ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар ОНХС-ийн хөрөнгийг урсгал зардал болон журам зөрчсөн төсөл арга хэмжээнд төлөвлөж, зарцуулсан, мөн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ гэрээний хугацаанд хийгдээгүй, бүрэн дуусаагүй 3,766.0 сая төгрөгийн зөрчил илэрч, аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүй зөрчил давтагдан гарч, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна. Цаашид хөрөнгө оруулалтын төсвийг зохистой, үр ашигтай удирдаж, гүйцэтгэлийг бүрэн ажиллах шаардлагатай байна.
5. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил өмнөх оноос 676.9 сая төгрөгөөр өсөж, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна.
6. Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийт зөрчлийн 43.7 хувь нь төсвийн төлөвлөлттэй холбоотой байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАД:

- Төсвийн төлөвлөлт, хөтөлбөр арга хэмжээний гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж, төсвийн урсгал зардлыг нэмэгдүүлэхгүйгээр төсвийг бодитой төлөвлөж, гүйцэтгэлийг бүрэн хангаж ажиллах;
- Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, үр дүнг тайлагнаж ажиллах;
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар шат, шатны төсөв захирагч нарт үүрэг өгч, биелэлтийг тооцон ажиллах;

АЙМГИЙН ТАТВАРЫН ГАЗРЫН ДАРГАД:

- Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөг орлогын нэр төрлөөр бүрэн биелүүлж ажиллах;

Дээрх зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2025 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



**ЗАВХАН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

81090 Улиастай, Завхан аймаг
Утас: 7575-1155, Факс: 7046-2550
И-мэйл: za@zavkhan.gov.mn

2025 04 21 № 7/390
танай _____ -ны № _____ Т

**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа, тайлантай холбоотой саналгүй болно.

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА  Б.ЧАДРААБАЛ



8109090561